 - (2) Operation and maintenance of air quality monitoring stations and analysis of monitoring data should be strengthened for evaluation and verification of air pollution control measures. When you compare PM₁₀ concentrations among different years, you should pick up monitoring data under the same meteorological conditions for the comparison in order to exclude effects of meteorology.
 - (3) Locations of air quality monitoring stations should be re-examined and re-located.
 - (4) Technologies on air pollutant emission inventory making and simulation implementation were relatively difficult for technology transfer during three years of the Project, and additional support on this field is necessary.
 - (5) Important matter on stack gas measurement is continuity of measurement practice. If staff does not practice the measurement for long period, technical ability of the staff diminishes. Measurement of all HOBs in Ulaanbaatar every three year is possible by two teams of two staffs. It means that such measurement can be done by trained members and with provided equipment of the Project.
 - (6) Revision of MNS standards is incomplete. Emission standards for HOBs are too tight compared with the ones for 2nd and 3rd power plants.
 - (7) AQDCC is requested to examine effectiveness of improved Ger stoves and

af

af

3

1 - 123

eg

[Signature]
[Signature]


improved fuels and measurement of low pressure boilers (coal fired water heaters). Guidelines and manuals for power plant boilers and HOBs were elaborated during the Project, but additional support for making of protocols, guidelines and manuals for small boilers and stoves and so on is necessary.

- (8) Education of PSD staff and proper role-sharing are necessary for continuing the Boiler Registration and Management System. Establishment of a network for cooperation with relevant authorities is necessary for enforcement of emission standards.
 - (9) Certificates on stack gas measurement were issued to the trained members of the Project. Technical abilities of two members are at upper level and other two are at middle level. Two at upper levels belong to NAQO and 4th power plant, and two at middle level belong to AQDCC. One of two staffs of stack gas measurement team must be at upper level. More training of staffs at middle level or support from NAQO and 4th power plant is necessary for making two sets of stack gas measurement teams.
 - (10) Calibration of air ratio of HOBs shows certain improvement and it is necessary to enforce HOB companies on implementation. Installation of cyclone is also effective, but maintenance is necessary for keeping the effect. Adding to the emission regulation, certification of good HOBs seems effective, but the certification has not started because of few data on boiler efficiency.
 - (11) Establishment of cooperation network among related authorities is a big and difficult issue and proper authorities for each regulation and each control measure should be discussed with Mongolian side.
3. Mr. BAT-ERDENE, Vice Mayor in charge of Ecology and Green Development and chairman of JCC understood the issues and promised necessary improvements for the next project.
 4. Mr. BAYAR-ULZII appreciated useful recommendations in the Draft Final Report and expressed his willingness of actual implementation by Mongolian side.
 5. Ms. TSEEPIL of Ministry of Environment and Green Development expressed her wish of training of staffs in local governments besides Ulaanbaatar in the next project. Mr. IWAI explained that the Project is considered a part of urban development of Ulaanbaatar City, which is one of the three priority areas of the Country Strategy Paper revised in April 2012 and possibility of training for local

a. j

af

g



staff will be discussed with relationship to this context.

6. Mr. YAMADA of JICA Advisory Mission pointed out the importance of establishment of cooperation mechanism among related authorities. He attended a meeting of National Committee for Air Pollution Reduction and felt lack of technical evaluation for air pollution issues. He also wishes possible contribution to such meeting and asked Mr. FUKAYAMA to list up the issues.

III. OPINIONS FROM JICA ADVISORY MISSION

1. Mr. YAMADA of JICA Advisory Mission expressed his opinion through the whole period of the Project at the end.
 - (1) The way of thinking by Mongolian side and the other donors can be summarized as follows. PM₁₀ and PM_{2.5} are the most harmful pollutants and contributions on PM₁₀ and PM_{2.5} concentrations by stoves in Ger area are the largest. So, all efforts have been concentrated for solving the issue as soon as possible. The strategy seems appropriate and all of you executed the plan according to the strategy
 - (2) However, he thinks that the issue is very difficult to be solved in short-term based on the experience in Japan. Such execution took fourteen years in Hokkaido. He also agrees on its necessity, but medium and long term strategy and plan are necessary for the execution.
 - (3) On the other hand, he also understands heavy responsibilities of Mongolian politicians and governmental staff on showing outcomes to the public. Emission reduction is verifiable and achievable and emission from power plants and HOBs can be most easily reduced. He has been wondering why they never take such approach for these five years.
 - (4) Compliance of emission standards by 2nd and 3rd power plants hides problem, but the inadequate standards for them should be corrected. Because 2nd and 3rd power plants have been said to be shut down, donors including Japan could not decide assistance for them. He expects several options become possible if Mongolian side declares to utilize 2nd and 3rd power plant for the future.
 - (5) He also pointed out that PM₁₀ and PM_{2.5} were important, but they were only a part of air pollution. SO₂ is also harmful and can be more easily reduced compared with reduction of PM₁₀ and PM_{2.5}. Contributions from natural soils are included in PM₁₀ and PM_{2.5} and effect of reduction is difficult to be



aq

q

5

1 - 125

g

felt by the public. He also wonders why they never execute reduction of SO₂ and the reduction may contribute to reduction of PM_{2.5}.

ANNEX I LIST OF THE PARTICIPANTS

Name	Position and Organization
< Mongolian Side >	
Mr. T. BAT-ERDENE	Project Director, Vice Mayor in charge of Ecology and Green Development
Ms. D. SUVDAA	Officer, Ministry of Economic Development
Ms. A. TSEEPIL	Officer, Ministry of Environment and Green Development
Mr. D. TSEESODROLDОО	Deputy Director, National Agency for Meteorology and Environment Monitoring (NAMEM)
Ms. S. ENKHMAA	Officer, National Agency for Meteorology and Environment Monitoring (NAMEM)
Mr. Ch. TSOG TSAIKHAN	Officer, Urban Development Policy Department of Mayor's Office of the Capital City
Mr. S. BAYAR-ULZII	Head, Engineering Facilities Department of the Ulaanbaatar City
Mr. N. SHINE-ORGIL	Officer, Inspection Agency of Capital City
Mr. Kh. GALIMBYEK	Deputy Director, Air Quality Department of the Capital City (AQDCC)
Mr. Ch. BATSAIKHAN	Project Manager, Director, AQDCC
< Japanese Side >	
Mr. Atsumu IWAI	Senior Representative, JICA Mongolia Office
Mr. Taizo YAMADA	JICA Advisory Mission, Senior Advisor on Environment, JICA
Mr. Junichi ARAI	Project Formulation Adviser, JICA Mongolia Office
Mr. Akeo FUKAYAMA	Team Leader, JICA Expert Team, Director, Environment Division, SUURI-KEIKAKU CO., LTD.
Mr. B. BATSUKH	Interpreter for JICA Expert Team

CG

af

Handwritten signature and initials, possibly 'Sunghee' and 'YH-5'.

Хавсралт 1.4-2 Бие дааж тогтвортой хөгжих нөхцлийг баталгаажуулах матриц (ХЗХ-ны 3 дах хуралдаан)

1. Төслийн хүрэх үр дүн тус бүрийн цаашид тогтвортой хэрэгжин, хөгжих нөхцлийн матриц

ҮР ДҮН-1

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжих хүчин зүйлс)</p>	<p>Хүрэх үр дүн-1 НАЧА болон холбогдох байгууллагын агаарын бохирдлын эх үүсвэрийг хянан шинжлэх болон агаарын орчны үнэлгээний чадавхийг сайжруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт 1.1 Эх үүсвэрийн инвенторын өгөгдлийн санг цаашид үр ашигтай ашиглан, тогтмол шинэчлэх. 1.2 Тархалтын загварчлалыг гарган, НАЧА болон холбогдох байгууллага нь бохирдлын эх үүсвэрт авч явуулах арга хэмжээний чухалчлан үзэж цаашид тогтвортой сайжруулан хэрэгжүүлэх талаар авч хэлэлцэх</p> <p>Үйл ажиллагаа 1.1 Хийгдсэн байгаа эх үүсвэрийн инвентор (ашиглах хэмжээ, ялгарлын АҮК-ын өгөгдөл зэрэг)-т дүн шинжилгээ хийж, эх үүсвэрийн ажлын хүрээ (хамрагдах бохирдуулах бодис, эх үүсвэр, эх үүсвэрийн мэдээллийн агуулга зэрэг) –ийг тогтоох 1.2 Суурин эх үүсвэрийн инвенторын судалгааг төлөвлөн хэрэгжүүлэх 1.3 Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторын судалгааг төлөвлөн хэрэгжүүлэх 1.4 Бусад эх үүсвэр (газрын хөрснөөс дэгдэх шороо тоос, хог хаягдлыг ил задгай шатаах, нүүрс ашигладаг газрын үнсний хяналт зэрэг)-ийн судалгааны аргачлалыг боловсруулан хэрэгжүүлэх 1.5 Суурин, хөдөлгөөнт болон бусад эх үүсвэрийн судалгааны үндэслэн суурь оны эх үүсвэрийн инвенторыг боловсруулах 1.6 Агаарын орчны мониторингийн өгөгдлийг цуглуулан дүн шинжилгээ хийж, өгөгдлийн зохистой байдлыг үнэлэх. 1.7 Суурь оны тархалтын загварчлалыг гаргах эх үүсвэрийн нарийвчлал болон тархалтын загварчлалыг боловсруулан гаргаж магадлах 1.8 Зорилтот он буюу авч хэрэгжүүлэх арга хэмжээний багцын инвенторыг тооцоолон гаргаж, уг инвенторыг ашиглан тархалтын загварчлалыг гаргаж агаарын орчинд нөлөөлөл байдлыг үнэлэх. 1.9 Өгөгдлийн сан, гарын авлагыг гаргах зэргээр эх үүсвэрийн инвенторын тогтолцоог бий болгох.</p>
<p>Технологийн үр чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнийг бүрдүүлэх</p>	<p>【Гол гишүүд】 Суурин эх үүсвэр : ДАВААЖАРГАЛ (НАЧА) , ЭНХМАА (ЦУОШГ) Хөдөлгөөнт эх үүсвэр : АЛТАНГЭРЭЛ (НАЧА) , ӨНӨРБАТ (УАЧА) , ЭНХМАА Бусад эх үүсвэр : САНЧИРБАЯР (НАЧА) , ЭНХМАА (ЦУОШГ) Тархалтын загварчлал : ДАВААЖАРГАЛ (НАЧА) , ЭНХМАА (ЦУОШГ)</p> <p>【Гишүүд】 Суурин эх үүсвэр : СЭДЭД (НАЧА) , БОЛДХҮҮ (ЭБЭХЯ) , МӨНХБАТ (БОАЖЯ) Хөдөлгөөнт эх үүсвэр : МӨНХБАТ (БОАЖЯ) , НЯМДАВАА (УАЧА) Бусад эх үүсвэр : СОНИНБАЯР (ДЦС 2) , БОЛДСАЙХАН (ДЦС 3) , АЛТАНГЭРЭЛ Тархалтын загварчлал : ОТГОНБАЯР (НАЧА) , БАЯСГАЛАН (НАЧА) , УРАНЦЭЦЭГ (НАЧА) , БАЯРМАГНАЙ (ЦУОШГУАЧА) , ОЮУНЧИМЭГ (ЦУОШГ /ИНМ) , БАТЖАРГАЛ (НАМЕМ/ИНМ) , ЛОДОЙСАМБА (МУИС) ,БАРХАСРАГЧАА (БОХЗТЛ)</p>
<p>Технологийн үр чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь сургалт, япон дахь дадлагажуулалт)</p>	<p>【Семинар】 Зуухны бүртгэл, хяналтын тогтолцоо болон эх үүсвэрийн инвенторын семинар (1 өдөр, Япон ба монгол дахь эх үүсвэрийн инвентор, 2010 оны 6 сар) Эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалын семинар (1 өдөр, эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалын үр дүн болон тэдгээрт тулгуурласан зөвлөгөөн, 2011 он 3 сар) Суурь оны инвентор, тархалтын загварчлалын семинар (1 өдөр, эх үүсвэрийн инвенторын нарийвчлалыг сайжруулах, инвентор, тархалтын загварчлалыг гарган хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох, 2011 он 6 сар)</p> <p>【Сургалт дадлага】 Инвентор, тархалтын загварчлалын дадлагын хичээл (4 өдөр, цаг уур болон агаарын орчны өгөгдлийг шинжлэн дүгнэх, суурин, хөдөлгөөнт, бусад эх үүсвэрийн инвентор, агаарт тархсан байдлыг харуулах тархалтын загварчлалын программыг ашиглах арга барил, 2011 оны 6 сар)</p>

	<p>【Ажлын байран дахь сургалт】 Хөдөлгөөний эрчмийн судалгааны хэлэлцүүлэг, хэрэгжилт (2010 оны 9 , 11 сар, 2011 оны 9 сар) Зуухны судалгааны зөвлөгөөн, хэрэгжилт (2010 оны 11 сар~2011 оны 2 сар) Автомашин ялгарлын АҮК-ыг тооцоолоход шаардлагатай мэдээлэл цуглуулах (2010 он 9 сар~12 сар) ДЦС-ын үнсэн сангаас хийсэж буй үнсийг хэмжих тухай зөвлөгөөн, хэрэгжилт (2010 он 12 сар, 3 сар, 5~6 сар) 【Япон дахь дадлагжуулалт, сургалт】 Инвентор, тархалтын загварчлалыг ашиглахтай холбогдсон агаарын бохирдлын удирдлагын менежментийн сургалт (2011 он 10 сарын 16- 29-ний хооронд төлөвлөж байгаа)</p>
Ур чадавхийг сайжруулах, ашиглах баталгаа	<p>Эх үүсвэрийн инвенторын тооцоолол болон тархалтын загварчлалын дүнг жилийн тайландаа оруулан мэдээллэж, Захирагчын захирамж гарсанаар инвентор, тархалтын загварчлалын ач холбогдол, шаардлагыг чухалчлан баталгаажуулсан болно. <u>НАЧА нь инвентор, тархалтын загварчлалыг голчлон хариуцдаггүй тул үр чадварыг сурч эзэмших, ашиглах тал дээр учир дутагдалтай байгаа.</u> Иймд эдгээр ажлыг голлон хариуцдаг ЦУОШГ-тай уялдаатай ажиллаж, ур чадавхийг сайжруулан эзэмших шаардлагатай байна.</p>
Тоног төхөөрөмж, байгууламж зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт	Тархалтын загварчлалд ашиглах компьютер зэргээр хангаж, эдгээр тоног төхөөрөмжийг үр дүнтэй ашиглах шаардлагатай.
Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	<p>Эх үүсвэрийн инвентор нь өгөгдлийн файл болгон нэгтгэсэн байгаа. НАЧА болон ЦУОШГ нь төсөл дуусах хүртэл 2 удаа эх үүсвэрийн инвенторыг шинэчлэн, нарийвчлалыг сайжруулах төлөвлөгөөтэй байгаа. Төсөл дууссанаас хойш цаашид шинээр бий болох эх үүсвэрийн инвентор болон энэ төслөөр хийгдсэн эх үүсвэрийн инвентор шинэчлэлийн талаархи мэдлэгээ ашиглан холбогдох байгууллагын эх үүсвэрийн инвенторыг гаргаж байх журам, тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх шаардлагатай байна.</p>
Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн зөвлөмж, стандартын үйл ажиллагааны аргачлалыг бүрдүүлэх)	Инвентор болон тархалтын загварчлалтай холбогдсон ажил хэргийн хуралдаан, сургалтанд хэрэглэсэн материалыг цаашид ашиглах боломжтой.
Байгууллагын мэргэжилтэнг бүрдүүлэх (мэргэжилтэний тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	<p>НАЧА-д эх үүсвэрийн инвентор, мөн тархалтын загварчлалын талаар суурь мэдлэг бүхий 2 мэргэжилтэн бий. Төслийн хугацаанд гишүүд өөрчлөгдсөн тул эх үүсвэрийн инвенторын талаархи суурь мэдлэгтэй мэргэжилтэн хэрэгтэй байгаа. Гэвч <u>НАЧА нь эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалыг голлон хариуцах үүрэгтэй байгууллага биш учраас техникийн талын суурь мэдлэг болон боловсон хүчинг сайжруулах тал дээр хязгаарлагдмал байна.</u> Иймд эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалыг гаргах ажлыг ЦУОШГ голлож удирдан явуулж, НАЧА нь хийгдсэн тархалтын загварчлалын үр дүнг агаарын бохирдолд авч явуулах арга хэмжээний төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулан тусгаж болох талаархи мэдлэг, үр чадвар бүхий мэргэжилтэнг бэлдэх нь зүйтэй юм.</p>
Төсөв бүрдүүлэлт	<u>Суурин, хөдөлгөөнт болон бусад эх үүсвэрийн инвенторын өгөгдлийг жил бүр шинэчилж байхын тулд шаардлагатай бодит хэмжилтийн судалгааны зардлыг төсөвт суулгаж өгөх шаардлагатай байна.</u>
Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	<p>НАЧА нь эх үүсвэрийн инвентортой холбогдох мэдээллийг цуглуулан, тухайн цуглуулсан мэдээлэлд үндэслэн УБ хотын хэмжээнд эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалыг гаргах ажлыг ЦУОШГ голлосон холбогдох бусад байгууллагаар даалгаж хийлгэх нь зүйтэй гэж мэргэжилтэний баг үзэж байна. Ийм тохиолдолд, НАЧА болон ЦУОШГ нь хоорондын ажлын уялдаа холбоогоо санамж бичиг зэргээр баталгаажуулах. НАЧА-гын хувьд, ЦУОШГ-тай хэдэн жилийн хугацаатай хамтарсан ажлын төлөвлөгөө гарган ажиллах саналтай байгаа. <u>Мөн хамтарсан төсөл хэрэгжүүлэх нь илүү зохистой гэж үзвэл хамтарсан төслийн төлөвлөгөөг боловсруулах нь зүйтэй юм.</u></p>

Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх	Мэргэжилтэний баг нь ЦУОШГ голлосон холбогдох бусад байгууллагад технологийн ур чадварыг эзэмшүүлэн, тархалтын загварчлалыг гаргах ажлыг даалган хариуцуулж хийлгэх нь тохиромжтой байх гэж үзэж байна.
Агаарын бохирдолд авах арга хэмжээг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Төслийн хугацаанд эх үүсвэрийн инвенторыг тооцоолон гаргасан үр дүн, тархалтын загварчлалд тулгуурласан агаарын орчны үнэлгээний дүнг оруулсан жилийн тайланг 2 удаа гаргах ёстой бөгөөд төсөл дууссанаас хойш цаашид ч жилийн тайландаа энэ талаархи мэдээллийг байнга оруулж байх хэрэгтэй юм. Инвенторыг тархалтын загварчлалыг гаргасанаар агаарын орчны агууламжийг таамаглан мэдэж ингэснээрээ Үндэсний стандарт MNS-ын ялгарлын стандартыг тогтоож чадах бөгөөд тархалтын загварчлалаар эх үүсвэрийн агууламжийг мэдсэнээр УБ хотын агаарын бохирдолд авч явуулах арга хэмжээний зөвлөмжийг гаргаж чаддаг болох юм.
--зэрэг	

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжих хүчин зүйлс)</p>	<p>Хүрэх үр дүн-2 УБ хотод утааны хийн хэмжилт байнга тасралтгүй хийгдэж байх</p> <p>Шалгуур үзүүлэлт 2.1 Төсөл хэрэгжих хугацаанд хамгийн багадаа 50 удаа утааны хийн хэмжилтийг хийсэн байх 2.2 Техникийн үндэслэл бүхий арга зүйн онолд тулгуурлан агаарын бохирдлын ялгарлын эх үүсвэрийн хяналт-шинжилгээг МХЕГ, УАЧА болон НАЧА зэрэг тухайн байгууллагуудаар хэрэгжүүлэх.</p> <p>Үйл ажиллагаа 2.1 Японд зохион байгуулагдах сургалтанд хамрагдсанаар утааны хийн хэмжилтийн онол, үндсийг сурч мэдэх. 2.2 Сорьцын цэгийг суурилуулахаар тогтон хэмжилт хийгдэх зуухыг сонгох 2.3 Стандартын хийн хэмжилтийн багаж төхөөрөмжөөр дадлага хийх 2.4 Рингелманы утааны агууламж харьцуулах хүснэгт зэргийн хялбарчилсан хэмжих арга болон гэрийн зуухыг хэмжилт хийх аргачлалын талаар судалж үзэх. 2.5 Хамрагдах зууханд хэмжилт хийж, утааны хийн байдлыг магадлах. 2.6 Утааны хийн хэмжилттэй холбогдсон гарын авлага (сорьцын цэг, ДЦС зуух, УХЗ болон гэрийн зуухны хэмжилтүүд, хялбарчилсан хэмжилт, багаж төхөөрөмжийн ашиглалт, хяналт)-г боловсруулах 2.7 Утааны хийн хэмжилттэй холбогдох гарын авлагын чанарыг сайжруулах 2.8 MNS-ын тогтоосон хэмжээ, хэмжилтийн аргын зөв, зохистой эсэхийг судлан, шаардлагатай бол өөрчлөх санал гаргах 2.9 Туршилтын хяналт-шинжилгээний аргачлалыг боловсруулах 2.10 Туршилтын хяналт-шинжилгээг явуулан утааны хийн байдлыг тодорхой болгон сайжруулах шаардлага тавих</p>
<p>Технологийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнийг бүрдүүлэх</p>	<p>Гол гишүүд : ДАВААЖАРГАЛ (НАЧА), ОТГОНБАЯР (НАЧА), БАЯРМАГНАЙ (УАЧА), ЭРДЭМБИЛЭГ(ЦУОШГ), ЭНХТҮВШИН (ДЦС 2), БАТБААТАР (ДЦС 3), НУГАДАЙ (ДЦС 3), АЛТАНГЭРЭЛ (ДЦС 4), МӨНХТУЛГА (ДЦС 4) ※Японд сургалтанд явсан ДАВААДОРЖ (НАЧА), ГАНЗОРИГ (ДЦС 3) нь өөр ажилд шилжсэн тул гишүүд өөрчлөгдсөн.</p>
<p>Технологийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь сургалт, япон дахь дадлагажуулалт)</p>	<p>【Японд дахь сургалт】 Утааны хийн хэмжилтийн талаар сургалт (лекц + дадлага, JFE технологи судлах зэрэг, 8 дадлагажигч x1 сар, 2010 он 7 сар~8 сар) 【Лекц】 Утааны хийн хэмжилтийн суурь мэдлэг (8 дадлагажигч, 2010 он 5сар) 【Дадлага】 Утааны хийн хэмжилтийн дадлага (6 өдөр, ДЦС 4 дээр 8 дадлагажигч болон бусад хүмүүс, 2010 он 8 сар~9 сар) Утааны хийн хэмжилт (21 зууханд 86 удаа, ДЦС 2, 3 дээр, УХЗ (14 газар), 2010 он 11 сар~12 сар, 2011 он 1 сар~3 сар) ※ДЦС-д хийгдсэн бодит хэмжилтэнд бүх дадлагажигч оролцсон ба УХЗ-ны хэмжилтэнд хяналт-шинжилгээний талын НАЧА, УАЧА, ЦУОШГ оролцсон. Дээж авах шинжилгээний дадлага (4 өдөр, ЦУОШГ дээр 6 дадлагажигч, 2010 он 5сар~6 сар)</p>
<p>Ур чадварыг бэхжүүлэх, ашиглах баталгаа</p>	<p>Утааны хийн хэмжилт хийх чадвартай боловсон хүч нь шат дараалалтайгаар ур чадавхи нь ахин хөгжиж байгаа ба лекц сургалтуудаас онолын мэдлэгтэй болсноор утааны хийн хэмжилтийг үргэлжлүүлэн хийсээр цаашид мэргэжлийн төвшинд хариуцан ажиллах боломжтой болно. Мөн одоо нэвтрүүлж эхэлж байгаа зуухны бүртгэл хяналтын тогтолцооны хүрээнд цаашид үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-д утааны хийн хэмжилт хийх ажлыг үүрэг болгохоор төлөвлөөд байгаа бөгөөд ингэснээр утааны хийн хэмжилтийг тогтмол хариуцан хийх болж, баталгаажих болно.</p>
<p>Тоног төхөөрөмж, байгууламж зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн</p>	<p>Утааны хийн хэмжилтийг хийхийн тулд маш олон төрлийн багаж төхөөрөмж шаардлагатай болдог. Уг төслөөс 2 иж бүрдэл утааны хийн хэмжилтийн төхөөрөмжийг нийлүүлэх боловч хэмжилт хийгдэх зуухны тооноос үзвэл хангалттай бус гэж тооцоолж байна. Төсөл үргэлжлэх хугацаанд утааны хийн хэмжилтийн багажны засвар-шинэчлэл, элэгдэх материал сэлбэгийг худалдан</p>

ашиглалтын хяналт	<u>авах зэрэгт шаардагдах зардлыг төлөвлөн, төсөвт тусгуулах шаардлагатай байна.</u> Утааны хийн хэмжилтийн төлбөрийн хэмжээг тогтоож, НАЧА-ны утааны хийн хэмжилтийн ажиллагааны зардалд зориулан нэмэр болгох талаар судалж үзнэ.
Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	Одоогийн байдлаар хэмжилтийн дүнг хүснэгтээр болон тусгай дэвтэрт тэмдэглэх байдлаар хадгалж байгаа. Боловсруулахаар төлөвлөж байгаа зуух бүртгэл хяналтын мэдээллийн санд оруулах тал дээр судалж үзэх.
Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн зөвлөмж, стандартын үйл ажиллагааны протоколыг бүрдүүлж цэгцлэх)	Утааны хийн хэмжилтийн технологийн гарын авлага боловсруулах төлөвлөгөөтэй байна. 1. Хэмжилтийн зааварчилгаа 1.1 Утааны хийн хэмжилтийн гарын авлага (2011 он 6 сар) 1.2 Утааны хийн хэмжилтийн протокол (2011 он 6 сар) 1.3 Хэмжилтийн амсар суурилуулах заавар (Тодорхой бус) 1.4 ДЦС-д утааны хий хэмжилт хийх заавар (Тодорхой бус) 1.5 Утааны дээж авч шинжлэгээ хийх заавар (Тодорхой бус) 1.6 НОВ, Гэр зуухны утааны хийн хэмжилтийн заавар (Тодорхой бус) 1.7 Багаж төхөөрөмжийн үйлчилгээ засварын заавар (Тодорхой бус) 1.8 Тоос хэмжих хялбарчилсан аргын заавар (Тодорхой бус) 2. Технологийн гарын авлага (Үндсэн материал) 2.1 Хэмжилт болон шинжилгээний ажлын урсгал (2011 он 6 сар) 2.2 Утааны хийн хэмжилтийн фланц бэлтгэх ажил гүйцэтгэх ажлын даалгавар-бүдүүвч зураг (2011 он 6 сар) 2.3 Утааны хийн хэмжилтийн фланц суурилуулах ажил гүйцэтгэх ажлын даалгавар (2011 он 6 сар)
Байгууллагын ажилтанг бүрдүүлэх (ажилтаны тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	Утааны хийн хэмжилтийн мэргэжилтэнг НАЧА-ны дотороос бэлтгэх боломжтой байна. Хэсэг хугацаанд боловсон хүчний дутагдлаа нөхөхийн тулд утааны хийн хэмжилтийг ДЦС-4-д захиалж хийлгэх боломж байгааг судалж үзэх. Ирээдүйдээ утааны хийн хэмжилтийн үйлчилгээтэй компани байгуулах боломжийг судалж үзэх. <u>Техникийн үр чадавхийн асуудлаас гадна, НАЧА-д МХЕГ-аас байцаагчийн эрх авсан хэмжилт хийх мэргэжилтэн байхгүй байгаа асуудал юм.</u> <u>Байцаагчын эрхийг зөвхөн ахмад түршлагатай ажилтанд олгодог бол хяналт-шинжилгээг газар дээр нь хийж байгаа залуу мэргэжилтэнд тусгайд нь хэмжилт хийх эрхийг олгох эсвэл НАЧА гэсэн нэгж байгууллагын хувьд байцаагч нь хэмжилтийг хянаж, залуу хэмжилтийн мэргэжилтэн болон ДЦС-4-ын мэргэжилтэн нь тухайн газарт хэмжилтийг хийдэг болох зэрэг тогтолцоог зөвшөөрвөл боловсон хүчнийг үр дүнтэй ашиглах боломжтой болох юм.</u>
Төсөв бүрдүүлэлт	Утааны хийн хэмжилт хийлгэж байгаа ААНБ-аас утааны хийн хэмжилтийн төлбөрийг авах талаар судалж үзэх ёстой. Мөн дээр дурьдсанчлан багаж төхөөрөмжийн үйлчилгээний зардал-элэгдэх материал зардлыг багтаасан бүтэн жилийн утааны хийн хэмжилтийг явуулах төсөвийг тооцож гаргах хэрэгтэй.
Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	2 иж бүрдэл багаж төхөөрөмж нийлүүлэх учраас НАЧА-д 2 хүнтэй*2 баг=4 хүнтэй утааны хийн хэмжилтийн мэргэжилтэн боловсон хүчинтэй болох хэрэгтэй боловч захиалгаар хийлгэх болон бусад байгууллагуудын уялдаа холбоог судалж үзэн мэргэжилтэний тоог багасгаж болно. <u>Ялангуяа утааны хийн хэмжилтийн хувьд хамруулах зуух ихтэй болохоор НАЧА-ны ажилтны гүйцэтгэх ажил ихсэх тул жил, сар, долоо хоног бүрээр ажил үүргийн төлөвлөгөөг боловсруулан түүний хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллах хэрэгтэй. Мөн утааны хийн хэмжилтийн дүн зэрэг өгөгдлийн хяналтын тухайд ч хариуцах хүн болон хяналт тавих аргыг тодорхой болгох шаардлагатай байна.</u>
Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах	УАЧА болон ЦУОШГ-д утааны хийн хэмжилтийн мэргэжилтэн боловсон хүчин бэлгэгдсэн байгаа бөгөөд байгууллага хоорондын санамж бичиг үйлдснээр утааны хийн хэмжилтийн үед туслалцаа авах боломжтой болно гэж үзэж байна. ДЦС-4-тэй ч мөн адил боловч ТӨХК учраас бодит зардал-хүн хүчний зардал зэргийг тооцож үзсэн гэрээний загвар гаргана гэж бодож байна.
Агаарын бохирдолд авах арга хэмжээг	Утааны хий хэмжилтийн мэргэжилтэн нь НАЧА-наас зууханд хориг тавих журамлах үед шаардлагатай ч гэж хэлж болхоор технологи бөгөөд MNS-ээс

<p>тогтоож, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох</p>	<p>тогтоосон ялгарлын стандартаас хэтэрч байгааг ШУ-ны үндэслэлтэйгээр батлах явдал бөгөөд зуухны ААНБ-д сайжруулах шаардлага тавьж чадна. Мөн утааны хийн хэмжилтийн дүн өгөгдлийг хуримтлуулан дүн шинжилгээ хийсэнээр MNS-ыг илүү тохиромжтойгоор сайжруулан, MNS-д үндэслэсэн ялгарлын хэм хэмжээний бодит баталгаатай байдлыг сайжруулж чадна.</p>
<p>----зэрэг</p>	

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжих хүчин зүйлс)</p>	<p>Үр дүн-3 Холбогдох байгууллагатай хамтран НАЧА-гын ялгарлын хэм хэмжээний хяналтын чадавхийг сайжруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт 3.1 Зуухны бүртгэлийг тогтмол шинэчлэн, инвенторын өгөгдөл болон ялгарлыг багасгахтай холбогдсон үйл ажиллагаанд суурь мэдээлэл болгон ашиглах</p> <p>Үйл ажиллагаа 3.1 Урьд хийгдсэн зуухны мэдээллийг цуглуулан цэгцэлж, японы зуухны бүртгэлийн тогтолцоог зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгох. 3.2 Зуухны бүртгэлийн тогтолцоонд хамрагдах зуухыг сонгон тэдгээрт хийх судалгааны төлөвлөгөө, хэрэгжилт 3.3 Зуухны бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэн цаашид боловсронгуй болгох 3.4 Зуух ашиглах зөвшөөрөл олгох (сайн ажиллагаатай зуухаар тодорхойлох) болзол, нөхцлийг тогтоох 3.5 Бүртгэл хяналтанд хамрагдах бүх зуухыг бүртгэн, болзол нөхцлийг хангасан зуухыг ашиглах зөвшөөрөл олгох</p>
<p>Технологийн ур чадвар эзэмшүүлэх боловсон хүчнийг бүрдүүлэх</p>	<p>Гол гишүүд : БАТСАЙХАН (НАЧА), ЦОЛМОН (НАЧА), ОТГОНБАЯР (НАЧА-гаас санал болгож байгаа) Гишүүд : ЦОГТСАЙХАН (ХХБХ), МӨНХБАТ (БОАЖЯ), МӨНХСАЙХАН (МХЕГ), ӨЛЗИЙЦЭЦЭГ (НМХГ), БАТБИЛЭГ (ОБХХМХ), ЭНХМАА (ЦУОШГ), ГАН-ОЧИР (ИБХ), ГАН-ОЧИР (ХЗАГ), СОНИНБАЯР (ДЦС 2), БОЛДСАЙХАН (ДЦС 3), БУРИАД (ДЦС 4), МӨНХЦОГ (НАЧА)</p>
<p>Технологийн ур чадвар эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь сургалт, япон дахь сургалт)</p>	<p>【Японд дахь сургалт】 Японд зохион байгуулагдах байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалт (лекц + дадлага, БОЯ, Токио хот, Кавасаки хот, Саппоро хот, Хитачинака ДЦС зэрэг, 5 дадлагажигч, 2 долоо хоногийн хугацаатай, 2010 оны 10 сар), Сургалтын агуулга Монголд зуухны бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардагдах зүйл-ийг боловсруулах</p> <p>【Семинар сургалт】 Зуухны бүртгэлийн тогтолцоо, инвентор шинэчлэлийн тогтолцоог бий болгох тухай семинар (1 өдөр, Японы зуухны бүртгэлийн тогтолцооны танилцуулга (мэргэжилтэн Эбихара), Монголын зуухны тогтолцооны талаар танилцуулга (БОАЖЯ), бусад 2010 он 6 сар) Зуухны бүртгэлийн тогтолцооны семинар нь (1 өдөр, Японы агаарын бохирдлоос хамгаалах хуулийн тухай танилцуулга (мэргэжилтэн Сакурай), Агаарын тухай хуулийн шинэчилсэн агуулга, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн ерөнхий агуулгын талаар (БОАЖЯ), Агаарын тухай хууль шинэчлэгдсэн агуулгын дагуу хийгдэх хяналт-шинжилгээний талаар (НМХЕГ), зуухыг бүртгэх тогтолцооны саналын талаар (мэргэжилтэн Фукаяама), байгаль орчны хяналт удирдлагын менежментийн сургалтын агуулгыг УБ хотын удирдах дээд албан тушаалтанд сурталчлан танилцуулахын тулд зохион байгуулагдсан. Семинарын дараа орлогч дарга Ганболд болон УБ хотын Ерөнхий менежер Батад хандсан зөвлөмжийг боловсруулсан, 2011 он 2 сар)</p>
<p>Ур чадавхийг бэхжүүлэх, ашиглах баталгаа</p>	<p>Зуухны бүртгэлийг тараах болон бөглөсөнийг цуглуулан авах тухайд, ҮСХ-ны зөвшөөрлийг албан ёсоор авсан тул тус мэдээллийн дүн, нэгтгэлийг тайлагнаж байх үүрэгтэй болсон. Мөн зуухны бүртгэлийн мэдээллийн сан нь инвентор, тархалтын загварчлалын системд оруулах өгөгдөл болох тул жил бүр бүртгэлийг явуулсанаар ур чадавхи сайжран бэхжих болно. НМХЕГ болон НАЧА хамтран хэрэгжүүлэх хяналт-шинжилгээний хэсэг болох утааны хийн хэмжилтийн өгөгдөл нь зуухны бүртгэлийн мэдээллийн санд хадгалагдах болно. Мэдээллийн сангийн мэдээллийг НАЧА зуухны ажиллагааг хянаж журамлахдаа үндэслэл болгохоос гадна ЦУОШГ хийх инвентор, тархалтын загварчлалын шинэчлэл, БОАЖЯ-ны Агаарын төлбөрийн тухай хуулийн төлбөрийн хэмжээг тогтооход ашиглах зэргээр байгаль орчны удирдлага, хяналтын менежментэд тус болох хэрэгцээтэй өгөгдөл болох юм. Тиймээс байгаль орчны удирдлага, хяналтын менежменттэй холбогдох албаны байгууллагуудыг өгөгдлөөр хангаж чадахуйц болох юм.</p>
<p>Тоног төхөөрөмж,</p>	<p>Төслийн хүрээнд зуухны бүртгэл, хяналтын тогтолцоонд зориулсан 1</p>

байгууламж зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт	компьютер болон программаар хангана.
Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	Зуухны судалгааны дүн зуухны болон яндангийн мэдээлэл –г WORD болон EXCEL хэлбэрээр хийж байгаа. Энэ намрын зуухны бүртгэлийн мэдээлэл, утааны хийн хэмжилтийн дүн мэдээг бүрдсэн үед мэдээллийн санг үүсгэх төлөвлөгөөтэй байна.
Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн зөвлөмж, стандартын үйл ажиллагааны аргачлалыг боловсруулах)	Мэдээллийн санг үүсгэх болон бүртгэлийн маягтыг хийж боловсруулах программын нарийвчилсан зааварчилал, гарын авлагыг боловсруулан гаргах төлөвлөгөөтэй байгаа.
Байгууллагын ажилтанг бүрдүүлэх (ажилтаны тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	Зуухны бүртгэлийн тогтолцоогоор бий болох мэдээллийн сангийн систем нь яваандаа сайжруулах засварлах шаардлагатай болох тул энэ засварлан сайжруулах ажлыг аутсорсинг буюу гадны байгууллагаар хийлгэж, НАЧА нь захиалагч тал болж өөрчилж шинэчлэх шаардлагатай зүйлийг тодорхойлж чаддаг байвал болох бөгөөд бүртгэлийн тогтолцооны бэлтгэл ажлыг хийснээр тогтолцооны талаархи ойлголтыг гүнзгийрүүлэн, бүртгэлийн өгөгдлийг боловсруулсанаар үйл ажиллагааны байдлыг ойлгож мэдэх нь зүйтэй юм. Мөн аутсорсинг хийхийн тулд мэдээллийн сан болон бүртгэлийн маягтыг оруулж боловсруулах, ашиглах талаар нарийвчилсан зааварчилгаа бэлдэх.
Төсөв бүрдүүлэлт	<u>Зуух ажиллуулах сургалт нь 3 жилийн хүчинтэй бөгөөд сургалтыг жил бүр зохион байгуулна. Бүртгэлийн маягтыг боловсруулах, зуух ашиглах эрхийн бичиг, зуухны галч, механикчын сургалтанд хамрагдсан батламж, сургалтын материал сэдвийг боловсруулах болон сургалтыг явуулах газрыг түрээслэх зардлыг жил болгон төсөвт суулгаж байх шаардлагатай</u>
Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	Зуухны бүртгэлийн мэдээллийн сан ашиглалтыг хариуцан ажиллах 2 ажилтантай болох нь зүйтэй гэж үзэж байна.
Байгууллага хоорондын уялдаа холбоог бүрдүүлэн сайжруулах	НАЧА нь УАЧА, БОХЗТЛ-ийн хийж байгаа утааны хийн хэмжилтийн дүн, ЭХЗХ-оос олгодог тусгай зөвшөөрөл (1500 кВт-аас дээших хүчин чадал бүхий зуух ажиллуулах зөвшөөрөл)-ийг олгож буй байдал, агуулгын талаар тодорхой мэдээлэлтэй байх талаар санамж бичиг солилцох. Мөн зуухны бүртгэлийн мэдээллийн санд байгаа өгөгдөл, мэдээллийг НМХГ, БОАЖЯ гэсэн байгууллагууд ч ашиглаж болохуйц болгон, бүртгэлийн агуулга, мэдээллийг мэдүүлэн танилцуулах
Агаарын бохирдолд авах арга хэмжээг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Зуухны бүртгэлийн мэдээлэл нь НАЧА-ын цаашид зууханд хяналт тавьж, журамлах ажлын гол суурь мэдээлэл нь болохоос гадна утааны хийн хэмжилтийн дүн, зуухыг сайжруулсан байдлын тэмдэглэл зэрэг нь тухайн зуухыг ашиглалтаас гарсаны дараа ч хадгалагдан үлдэх болсоноор янз бүрийн харьцуулалт, судалгааг хийхэд үндсэн мэдээлэл нь болж өгөх юм. Мөн зуухны бүртгэлийн мэдээлэл нь агаар бохирдуулах эх үүсвэрийн инвенторыг гаргахад ашиглагдах бөгөөд тухайн мэдээлэлд тулгуурлан нэмэлт хийгдэх судалгааг төлөвлөх боломжтой болох юм.
--зэрэг	

Үр дүн 4

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжих хүчин зүйлс)</p>	<p>Үр дүн-4 НАЧА-аас агаарыг бохирдуулах бодисын эх үүсвэрт авах арга хэмжээг санаачлан гаргах</p> <p>Шалгуур үзүүлэлт 4.1 20-оос доошгүй агаар бохирдуулах бодисын гол эх үүсвэрт (суурин эх үүсвэр) үзлэг оношлогоог явуулан, түүнд авах арга хэмжээний төсөл санал гаргаж өгөх 4.2 Зуухны хэмжилтийн амсарын цэгийг гарган, шаталтыг нэмэгдүүлэх зэрэг ажиллагааг сайжруулах бодлогын талаар зуух эрхлэгч, эзэмшигч нартай хэлэлцэн зөвшилдож, хэлэлцүүлгийн товч тэмдэглэлийн эмхтгэлтэй болох.</p> <p>Үйл ажиллагаа 4.1 MNS болон зуухны бүртгэлийн тогтолцооны талаар семинар хийх 4.2 Шаталтын хяналт болон агаарын бохирдлоос хамгаалах арга хэмжээний тухай ерөнхий онолын талаар лекц хийх. 4.3 Агаар бохирдуулагч голлох эх үүсвэрт үзлэг оношилгоо хийж байгууламж болон хяналтын байр сууринаас авах арга хэмжээний санал гаргах. 4.4 Агаар бохирдуулагч голлох эх үүсвэрт авах арга хэмжээний саналыг семинараар танилцуулах. 4.5 Муу болон сайн ажиллагааг нягталж үзэх. 4.6 Нийт хамруулах зуух нь ялгарлын стандарт зэрэг хуулийн үүрэгээ биелүүлж чаддаг байхаар тогтолцооны санал гаргах.</p>
<p>Технологийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнийг бүрдүүлэх</p>	<p>Гол гишүүд : СЭДЭД (НАЧА), ЦОЛМОН (НАЧА-с санал болгож байгаа), док. ЦЭЭН-ОЙДОВ (ШУТИС), Гишүүд : СОНИНБАЯР (ДЦС 2), БОЛДСАЙХАН (ДЦС 3), БУРИАД (ДЦС 4), ГАН-ОЧИР (ИБХ), ГАН-ОЧИР (ХЗАГ), БАТТӨР (ШУТИС), ОТГОН (БҮҮНА), БИЛГҮҮН(БЭХХТ)</p>
<p>Технологийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь сургалт, япон дахь сургалт)</p>	<p>【Лекц】 АБ-д авах арга хэмжээ-Эрчим хүч дулаан хэмнэлтийн талаарх семинар (4 өдөр, Ҷхолбогдох агуулгыг 「ажлын гүйцэтгэл/чанарын хяналт」 хэсгээс харах, 2010 он 10 сар) АБ-д авах арга хэмжээнд зуухны хүчин чадал ашиглалтын хяналтын сургалт (НАЧА, ДЦС, Их сургуулийн холбогдох хүмүүс 1 өдөр, НАЧА, УХЗ-ны холбоотой хүмүүс 1 өдөр, 2011 он 2,3 сар) 【Сургалтын материал, сэдэв боловсруулалт】 Зуухны галчийн сургалтын бичиг материал боловсруулах (1) УХЗ ажиллуулах үндсэн зарчим, 2) Дулаан дамжуулалтын онол, 3) Шаталтын онол, 2011 он 6-9 сар) 【Дадлагажих сургалт】 АБ-д авах арга хэмжээний зуухны дулаан хяналтын дадлагажих сургалт (ДЦС-3 дээр 1-өдөр, УБТЗ-ын Засварын төв дээр 2-өдөр 2010 он 12 сар, УХЗ-дээр 1-өдөр 2011 он 2 сар) 【Ажлын байран дахь сургалт】 АБ-д авах арга хэмжээг судалж үзэх (ДЦС (Ялангуяа ДЦС-3-н зуухны тухайд буцламтгай үет шаталтад системтэй болгон сайжруулах хүсэлтийн саналыг боловсруулах), Үйлдвэр-1, УХЗ-2 2010 он 6 сар) АБ-д авах арга хэмжээний хүрээнд Эрчим хүч дулаан хэмнэлт (ЭХДХ)-ийн потенциал нөөцийг оношлох (ДЦС-Үйлдвэр зэрэг 2010 он 6 сар) АБ-д авах арга хэмжээний хүрээнд ЭХДХ-ийн хялбарчилсан оношлогоо (ДЦС(3), Үйлдвэр (8), оффис (1), УХЗ (3) 2010 он 10 сар) АБ-д авах арга хэмжээний хүрээнд ЭХДХ-ийн дэлгэрэнгүй оношлогооны хэрэгжүүлэлт, тайлбар (Үйлдвэр (2), 2011 он 1,3 сар, оношлогоо (нэмж 2 үйлдвэр) (6 сар))</p>
<p>Ур чадавхийг бэхжүүлэх, ашиглах баталгаа</p>	<p>Одоогийн НАЧА-ны бүтцээр технологийн эзэмшилт болон цаашид тогтвортой хөгжүүлэн авч явахад зарим нэг дутагдалтай зүйл байгаа учраас Их сургууль зэрэг улсын гадны байгууллагуудтай холбоо тогтоож хамтран ажиллавал сайн байна.</p>
<p>Тоног төхөөрөмж, байгууламж зэрэг</p>	<p>Том хэмжээний багаж биш боловч авах арга хэмжээний оношилгооны зориулалттай багажтай болох шаардлагатай. (даралт-температурын мэдрэгч</p>

ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт	болон дата цуглуулагч, хэт авианы зарцуулалт хэмжигч, термо графикийн камер, хэт авиагаар хий алдалт хайгч зэрэг)
Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	Зуухны чанарын үнэлгээний дүн хүснэгт хэлбэрээр ЭХДХ-ийн оношлогооны дүнгийн дэлгэрэнгүй тайлан гаргасан байгаа бөгөөд одоогийн байдлаар зуухны чанарын үнэлгээний дүн 3, ЭХДХ-ийн оношлогооны дүнгийн 2 тайлан байгаа нь мэдээллийн хэмжээний хувьд бага ч эдгээрийг бүрдүүлэх хянах тогтолцоог бий болгох шаардлагатай байна. ЭХДХ-ийн дэлгэрэнгүй оношлогооны тайланд: 1) ЭХДХ-ийн оношлогооны дүнгийн тойм, 2) үйлдвэрийн талаархи ерөнхий агуулга, 3) ЭХДХ-ийн оношлогооны агуулга, 4) монгол талын оролцогчдод ЭХДХ-ийн оношлогоо болон хэмжилтийн багаж төхөөрөмжтэй ажиллах талаар удирдан, зааж сургах тухай орсон.
Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн зөвлөмж, стандартын үйл ажиллагааны аргачлалыг бүрдүүлж цэгцлэх)	Агаарын бохирдолд авах арга хэмжэ, Эрчим хүч дулаан хэмнэлтийн сургалтын материалыг цаашид ашиглах боломжтой. Агаарын бохирдолд авах арга хэмжээний талаархи сургалтын материал 1) Нүүрсний талаархи ерөнхий мэдлэг, 2) Зуухны АҮК-ын ерөнхий агуулга, 3) Зуухны АҮК-ын шинжилгээний суурь ойлголт, мэдлэг, 4) Зуухны АҮК-ын хичээл, 5) Зуухны АҮК-ын байнгын хяналт, 6) Зуухны АҮК-ыг сайжруулах, 7) Японы цэвэр нүүрсний технологи, 8) Зуухны гэмтэл, засварын жишээ болон авах арга хэмжээ, 9) УХЗ-ны тухай ЭХДХ-ийн техникийн оношлогооны талаархи сургалтын материал 1) Японы ЭХДХ-ийн байдал (ЭХДХ-ийн хэрэгцээ шаардлага, японы ЭХДХ, түүний хяналтын тогтолцоо, авч явуулах арга хэмжээний хэрэгжилтийн явц), 2) ЭХДХ-ийн технологи (Зуух, хийн компрессор, сэнс салхилуур, гэрэлтүүлэгийн ЭХДХ), 3) Японд ЭХДХ-ийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
Байгууллагын ажилтанг бүрдүүлэх (ажилтаны тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	<u>Агаарын бохирдолд авч явуулах арга хэмжээний хувьд НАЧА-нд зуухны 1 мэргэжилтэн байгаа бөгөөд цаашид нарийн мэргэжлийн мэдлэг бүхий боловсон хүчинг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. 2011 оны зун зуухны үйл ажиллагаа эрхлэгч компанид ажиллаж байсан мэргэжилтэн ажиллах болсон тул цаашид технологийн үр чадварыг дүгнэж үнэлэх нь зүйтэй юм. ЭХДХ-ийн хувьд, НАЧА-ын Х/Т туйлын идэвхтэй хамтран ажиллаж байгаа ч мэргэжлийн талын мэдлэг, суурь дутагдалтай байгаа тул НАЧА нь дангаараа ЭХДХ-ийн оношилгоо хийх нь бэрхшээлтэй гэж үзэж байна.</u>
Төсөв бүрдүүлэлт	Төслийн хугацаанд хэрэгцээтэй багаж төхөөрөмж болон сольж сэлбэх материалаар хангах төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай.
Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	НАЧА-ын хувьд цаашид боловсон хүчингээ сайжруулан нэмэгдүүлэхээс хамаарах ч бэлтгэл оношилгоог хийж, оношлогоонд хамрагдах байгууламжийг сонгон тогтоож, бодит дэлгэрэнгүй оношлогоог холбогдох байгууллагаар даалган хийлгэх нь зүйтэй болов уу гэж мэргэжилтэний баг үзэж байна. Үүнд шаардагдах оношлогооны зардлыг тухайн ажил гүйцэтгэгч байгууллага нь хариуцан даах ёстой юм.
Байгууллага хоорондын уялдаа холбоог бүрдүүлэн сайжруулах	Мэргэжилтэний баг нь агаарын бохирдолд авах арга хэмжээний хувьд ШУТИС-ын харьяа Эрчим хүчний инженерийн сургуульд, ЭХДХ-ийн хувьд ШУТИС-д байгуулагдсан БЭХХ-ийн төвд тус тус технологийн үр чадавхийг эзэмшүүлэн, холбогдох оношлогоог хариуцуулан даалгаж хийлгэх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн НАЧА нь ШУТИС-ийн харьяаны зуух оношлогооны лабораторитой хамтран ажиллах талаар судлан үзэх хүсэлтэй байгаа.
Агаарын бохирдолд авах арга хэмжээг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Энэ салбар нь ялгарлын стандартын хэм хэмжээг хэтрүүлсэн байгууламжид ажиллагаагаа сайжруулах талаар зөвлөн удирдаж ажиллахад чиглэх бөгөөд ялангуяа НАЧА нь технологийн тал дээр голлон ажиллаж сайжруулахаар ажиллах үүргийг гүйцэтгэх болно. Хөрөнгө санхүүжилтын тал дээр ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж байгаа 2 үе шаттай хөнгөлөлттэй зээл (ХШХЗ)-ийг ашиглах нь зохимжтой гэж үзэж байна. Гэвч ХШХЗ-д жижиг дунд үйлдвэрүүд хамрагдах тул улсын байгууллагын хувьд тусд нь хөрөнгө санхүүжилтыг судлах шаардлагатай юм.
--зэрэг	

Үр дүн-5

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжих хүчин зүйлс)</p>	<p>Үр дүн-5 НАЧА болон холбогдох байгууллага нь төслийн хүрэх үр дүн 1-4 ийг нэгтгэн, агаарын бохирдлын хяналтын менежментэд тусган, мэдээллийг нийтэд тараан дэлгэрүүлэх боломжтой болох.</p> <p>Шалгуур үзүүлэлт 5.1 Х/Т болон Х/Т болон А/Х-ийн гишүүд нь хурлын протокол хөтлөх зэрэг илтгэл мэдээллийг ашиглан, АББҮХ болон нийслэлийн иргэдтэй уг төслийн үр дүнг цаашид хамтран эзэмших</p> <p>Үйл ажиллагаа 5.1 Агаарын бохирдлын талаархи Японы мэдлэг, чиг баримтлалыг сургалт, семинараар танилцуулах 5.2 Х/Т болон А/Х-ын гишүүд Японд сургалт дадлаганд хамрагдсанаар японы байгаль орчны удирдлагын менежментийн талаар сурч мэдэх 5.3 Мэргэжилтэний баг нь тогтмол Х/Т болон А/Х-ын гишүүдтэй зөвлөгөөн хийж, агаар мандалыг хамгаалах удирдлагын менежментийн зохистой зөв саналыг боловсруулан гаргаж, хурлын протокол хөтлөх зэргээр тайлан болгон гаргах 5.4 Х/Т болон А/Х-ийн гишүүд нь хандивлагч тал, байгууллагын тусламжтайгаар хэрэгжиж буй нийслэлийн хэмжээний агаарын орчны хяналтын хөтөлбөрт хувь нэмрээ оруулах. 5.5 Х/Т болон Х/Т ба А/Х-ийн гишүүд хамтарч 2-оос доошгүй удаа агаарын бохирдолд авах арга хэмжээтэй холбоотой сурталчилан таниулах зорилго бүхий сургалт, семинарыг зохион байгуулах.</p>
<p>Технологийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнийг бүрдүүлэх</p>	<p>Гол гишүүд : МӨНХЦОГ (НАЧА), БАТСАЙХАН (НАЧА), ЦОЛМОН (НАЧА) Гишүүд : МӨНХБАТ (БОАЖЯ), ӨЛЗИЙЦЭЦЭГ (НМХЕГ), ЭНХМЭЭ (ЦУОШГ) Санал болгох : ЦОГТСАЙХАН (ХХБХ), БАТБИЛЭГ (ОБХХМХ), САРАН (БОАЖЯ), НЯМДОРЖ (НМХГ), ДАВААСҮРЭН (ЭБЭХЯ), БОЛОРМАА (ЗТБХБЯ)</p>
<p>Технологийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь сургалт, япон дахь сургалт)</p>	<p>【Япон дахь сургалт】 Японд зохион байгуулагдах байгаль орчны удирдлагын менежментийн сургалт (лекц + дадлага, БОЯ, Токио хот, Кавасаки хот, Саппоро хот, Хитачинака ДЦС зэрэг, 5 дадлагажигч 2 долоо хоногийн хугацаатай, 2010 он 10 сар) сургалтын агуулга нь монголд зуухны бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай зүйлс] агуулгыг боловсруулах Агаарын бохирдлын удирдлагын менежментийн сургалт (инвентор, тархалтын загварчлалын агаарын бохирдлын удирдлагын менежментэд ашиглах талаар, 2010 он 10 сард зохион байгуулахаар төлөвлөж байгаа) 【Семинар】 - Зуухны бүртгэл, хяналтын тогтолцоо (ЗБХТ), инвенторыг шинэчлэх тогтолцоог бий болгох талаар семинар (1 өдөр, япон монголын зуухны бүртгэл, мэдүүлгийн нарийвчлалын талаар зэрэг, 2010 он 6 сар) -ЗБХТ-ны талаар семинар (1 өдөр, японы зуухны бүртгэл, хяналтын тогтолцооны тухай, Монгол улсын Агаарын хуулийн шинэчилсэн агуулга, Агаарын бохирдлын төлбөрийн хуулийн ерөнхий агуулгын талаар, шинээр нэвтрүүлж буй зуухны бүртгэл, хяналтын тогтолцооны танилцуулга, зөвлөгөөн, 2011 он 2 сар) 【Бусад】 -ЗБХТ-г нэвтрүүлэхтэй холбогдуулсан Засаг даргын захирамж (2011 он 8 сар, зуухны бүртгэл мэдүүлэг, зуух ажиллуулах сургалтанд хамрагдах, утааны хийн хэмжилт зэрэг ажилд хамтран ажиллах талаар харилцан зөвшилцөлд хүрэхийг наад захын болзол шаардлага болгон зуух ашиглах зөвшөөрлийг олгох зэрэг холбогдох зарчмууд) -ЗБХТ-г нэвтрүүлэхтэй холбогдуулсан Үндэсний Статистикийн Газрын зөвшөөрөл (2011 он 9 сар) Өнөөг хүртэл НАЧА хариуцан гүйцэтгэх эх үүсвэрийг хянаж журамлахад шаардлагатай гэсэн тус бүртгэл хяналтын тогтолцоог бий болгоход голлон анхаарч ажиллаж ирсэн бөгөөд цаашид инвентор, тархалтын загварчлалыг ашигласан агаарын бохирдолд авч явуулах арга хэмжээний зөвлөмж, MNS -ыг шинэчлэх зэрэг асуудалд анхаарах ажиллах төлөвлөгөөтэй байна.</p>

Ур чадавхийг бэхжүүлэх, ашиглах баталгаа	НАЧА-с хэрэгжүүлэх агаарын бохирдлын удирдлагын менежментийн үйл ажиллагааг аль болох хууль тогтоомж, захирамж гаргуулах хэлбэрээр агуулгыг тодотгон, баталгаажуулж авах нь чухал юм. Ингэснээр төсөв, боловсон хүчнийг бүрдүүлэх боломжтой болох ба хяналт удирдлагын ажиллах чадварыг ашиглах боломж ч нэмэгдэх болно
Тоног төхөөрөмж, байгууламж зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт	Энэ салбарын хувьд чухал шаардлагатай багаж төхөөрөмж байхгүй.
Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	Тогтолцоог бий болгохоор ажиллах явцад боловсруулсан холбогдох байгууллагатай харилцсан баримт бичгийг эмхлэн хадгалах нь зүйтэй юм.
Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн зөвлөмж, стандартын үйл ажиллагааны аргачлалыг бүрдүүлж цэгцлэх)	Тогтолцоог бий болгохоор ажиллах явцад бүрдүүлсэн баримт бичиг зэргийг дурьдсан бичиг байвал эмхлэн хадгалах.
Байгууллагын ажилтанг бүрдүүлэх (ажилтаны тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	Дарга, дэд даргын хувьд холбогдох байгууллагатай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулан гүнзгийрүүлж, боловсон хүчний ажлын эрх үүрэг, хариуцлагын хүрээг өргөжүүлэх талаар чармайн ажиллах хэрэгтэй байна.
Төсөв бүрдүүлэлт	ЗБХТ шиг тусгай тогтолцоо, журмыг бий болгож жил бүр хэрэгжүүлэх шаардлагатай ажил болох тул үүнд зарцуулагдах ажиллах хүчний зардал, сэлбэх материалын зардал багтаан төсөв гаргадаг болох нь НАЧА-ны гүйцэтгэх ажил үүргийг улам тодотгон өгч, төсөв болон боловсон хүчнээ нэмэгдүүлж сайжруулах боломжтой болно гэж үзэж байна.
Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	<u>Дарга болон дэд даргаас гадна дараахи албан тушаалтаныг бэлтгэн янз бүрийн удирдлага хяналтын шийдвэрийг шүүрхай хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлэх. Мөн гүйцэтгэх ажил болон хариуцах ажилтанг тогтоон шийдэж, ажлын бүтээмжийг сайжруулахын зэрэгцээ хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх</u>
Байгууллага хоорондын уялдаа холбоог бүрдүүлэн сайжруулах	<u>Технологийн болон бодлогын тал дээр НАЧА нь холбогдох байгууллагатай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог бий болгох шаардлагатай байгаа тул БОАЖЯ, ЭБЭХЯ, ЦУОШГ, УАЧА, БОХЗТЛ, Инженерийн байгууламжийн хэлтэс, НМХЕГ зэрэг байгууллагуудтай санамж бичиг солилцох зэргээр харилцаа холбоогоо бэхжүүлэн ажиллах.</u>
Агаарын бохирдолд авах арга хэмжээг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Агаарын тухай хууль, Энергийн хуульд заагдсан агаарын бохирдлын хяналт, удирдлага болон холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа холбоонд НАЧА-ны зүгээс шамдан ажиллах боломжтой удирдлага менежментийн асуудлыг эрэлхийлэн олж, мөн шийдвэрлэх шаардлагатай шинэ асуудлыг захирагчийн түвшинд санал болгон тавьж, зөвлөмж гаргах зэргээр өөрсдийн хариуцан гүйцэтгэх ажлыг бий болгон, НАЧА-ны хариуцлага, эрх үүрэг оролцооны асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.
--зэрэг	


ТӨСЛИЙН ЗОРИЛГО

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжих хүчин зүйлс)</p>	<p>Төслийн зорилго Нийслэл болон бусад холбогдох байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх, ур чадавхийг сайжруулахад голлон анхаарч, УБ хотын агаарын бохирдолд авах арга хэмжээний хэрэгжилт, хяналтын чадавхийг сайжруулан бэхжүүлэх</p> <p>Шалгуур үзүүлэлт</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн агаарын чанарын алба нь бусад холбогдох байгууллагатай хамтран төсөл хэрэгжилтийн хугацаанд 2 удаа эх үүсвэрийн хог хаягдлын эмиссийн инвенторын нэгдсэн дүн, агаарын орчны үнэлгээний дүн болон ялгарлын хэмжилтийн дүнг оруулсан жилийн тайлан гаргах 2. Нийслэлийн агаарын чанарын алба нь бусад холбогдох байгууллагатай хамтран УБ хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчын ажлын албаны даргад хандан жилийн тайландаа үндэслэн төслийн хугацаанд агаарын бохирдолд авч явуулах арга хэмжээний талаархи 5 саналыг боловсруулан, өргөн барьж зөвлөмж болгох 3. Нийслэлийн агаарын чанарын алба нь бусад холбогдох байгууллагатай хамтран, төслийн хугацаанд хийгдэх бүх дугуй ширээний ярилцлага болон бусад уулзалт ярилцлагаар төслийн хэрэгжилтийн явцын дүнг тайлагнан танилцуулах.
<p>Технологийн ур чадвар эзэмшүүлэх боловсон хүчнийг бүрдүүлэх</p>	<p>Үр дүн-1 ДАВААЖАРГАЛ (НАЧА), АЛТАНГЭРЭЛ (НАЧА), САНЧИРБАЯР (НАЧА), ЭНХМАА (ЦУОШГ), ӨНӨРБАТ (УАЧА)</p> <p>Үр дүн-2 Гол гишүүд : ДАВААЖАРГАЛ (НАЧА), ОТГОНБАЯР (НАЧА), БАЯРМАГНАЙ (УАЧА), ЭРДЭМБИЛЭГ (БОХЗТЛ), ЭНХТҮВШИН (ДЦС 2), БАТБААТАР (ДЦС 3), НУГАДАЙ (ДЦС 3), АЛТАНГЭРЭЛ (ДЦС 4), МӨНХТУЛГА (ДЦС 4)</p> <p>Үр дүн-3 БАТСАЙХАН (НАЧА), ЦОЛМОН (НАЧА), ОТГОНБАЯР (НАЧА –наас санал болгож байгаа)</p> <p>Үр дүн-4 СЭДЭД (НАЧА), ЦОЛМОН (НАЧА-наас санал болгож байгаа), док. ЦЭЕН-ОЙДОВ (ШУТИС)</p> <p>Үр дүн-5 МӨНХЦОГ (НАЧА), БАТСАЙХАН (НАЧА), ЦОЛМОН (НАЧА)</p>
<p>Технологийн ур чадвар эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь сургалт, япон дахь сургалт)</p>	<p>Үр дүн-1 【Семинар】 Зуухны бүртгэл, хяналтын тогтолцоо (ЗБХТ), эх үүсвэрийн инвентор (1 өдөр, 2010 он 6 сар) Эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлал (1 өдөр, 2011 он 3 сар) Суурь оны инвентор, тархалтын загварчлал (1 өдөр, 2011 он 6 сар) 【Сургалт】 Инвентор, тархалтын загварчлал (4 өдөр, 2011 он 6 сар) 【Ажлын байран дахь сургалт】 Хөдөлгөөний эрчмийн судалгаа (2010 он 9 сар, 11 сар, 2011 он 9 сар) Зуухны байгууламжаар биечлэн явж хийсэн судалгаа (2010 он 11 сар~2011 он 2 сар) Автомашин ялгарлын АҮК-ыг тооцоолохын тулд мэдээлэл цуглуулах, ДЦС-ын үнсэн сангаас хийсэх үнсийг хэмжих зэрэг үйл ажиллагаа 【Япон дахь сургалт】 Инвентор, тархалтын загварчлалыг АБ-ын хяналт удирдлагын менежментэд ашиглах (2011 он 10 сард явагдахаар төлөвлөж байгаа)</p> <p>Үр дүн-2 【Япон дахь сургалт】 Утааны хийн хэмжилтийн сургалт (лекц+дадлага, 8 хүнх1 сар, 2010 оны 7 -8 сар) 【Лекц】 Утааны хийн хэмжилтийн суурь мэдлэгийн сургалт (8 хүн, 2010 он 5 сар) 【Дадлага】 Утааны хийн хэмжилтийн дадлаг (6 өдөр, 8 хүн ба бусад, 2010 оны 8-9 сар) Утааны хийн бодит хэмжилт (21 зууханд 86 удаа, ДЦС дээр (ДЦС 2, 3), УХЗ (14</p>

<p>Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт</p>	<p>Эх үүсвэрийн инвенторыг өгөгдлийн файл болгож цэгцэлсэн. НАЧА болон ЦУОШГ нь төсөл дуусахаас өмнө 2 удаа эх үүсвэрийн инвенторын шинэчлэлийг хийсэн Төсөл дууссанаас хойш цаашид шинээр бий болох эх үүсвэрийн инвентор болон тус төслийн хүрээнд хийгдсэн эх үүсвэрийн инвентор шинэчлэлийн талаархи мэдлэгээ ашигласан холбогдох байгууллагын эх үүсвэрийн инвенторыг боловсруулж ажиллах тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх шаардлагатай байна.</p>

	Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн гарын авлага, стандартын үйл ажиллагааны аргачлалыг бүрдүүлэх)	Инвентор, тархалтын загварчлалын моделийн гарын авлага (2012 оны 10 сар) Хөдөлгөөнт эх үүсвэрийн гарын авлага (2012 оны 11 сар)
	Байгууллагыг боловсон хүчнээр хангах (мэргэжилтэний тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	НАЧА-нд эх үүсвэрийн инвентор, мөн тархалтын загварчлалын талаар суурь мэдлэг бүхий 2 мэргэжилтэн байдаг. <u>Гэвч НАЧА нь эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалыг голлон хариуцаж ажиллах байгууллага биш учраас техникийн талын суурь мэдлэг, боловсролыг сайжруулах, боловсон хүчнийг нэмэгдүүлэх тал дээр хязгаарлагдмал байдаг.</u> Иймд ЦУОШГ болон УАЧМА-ны голлон хариуцаж эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалын моделийг боловсруулан гаргаж, НАЧА нь тархалтын загварчлалын дүнг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээтэй хэрхэн уялдуулж болохыг шийдвэрлэн дүгнэж чадахуйц боловсон хүчнийг бэлтгэх тал дээр ажиллах нь зүйтэй байна.
	Төсөв бүрдүүлэлт	<u>Суурин, хөдөлгөөнт болон бусад эх үүсвэрийн инвенторын өгөгдлийг жил бүр шинэчилж байхын тулд шаардлагатай бодит хэмжилтийн судалгааны зардлыг төсөвт суулгаж өгөх шаардлагатай байна.</u>
	Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	Мэргэжилтний баг нь “НАЧА нь эх үүсвэрийн инвентортэй холбоотой мэдээллийг цуглуулж, тухайн цуглуулсан мэдээлэлд тулгуурлан ЦУОШГ-аар төлөөлүүлсэн холбогдох байгууллага нь УБ хотын хэмжээнд эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалыг боловсруулж гаргах ажлыг хариуцан ажиллах нь зохистой” гэж үзэж байгаа юм. Төсөл дууссанаас хойш цаашдын байдлыг шийдвэрлэхийн тулд НАЧА болон ЦУОШГ-ын ажлын харилцаа холбоог санамж бичиг байгуулах зэргээр тодорхой болгож өгөх. НАЧА-гын хувьд, ЦУОШГ-тай хэдэн жилийн хугацаатай хамтарсан төсөл хэрэгжүүлэх талаар санал тавих хүсэлтэй байгаа. <u>Хамтарсан төсөл хэрэгжүүлэх нь илүү зохистой гэж үзвэл хамтарсан төслийн нарийвчилсан зааварчилгааг боловсруулах нь зүйтэй юм.</u>
	Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах	Мэргэжилтний баг нь НАЧА-наас гадна ЦУОШГ болон УАЧМА голлосон холбогдох байгууллагад техникийн ур чадавхийг эзэмшүүлж ирсэн. Иймд эдгээр байгууллагад тархалтын загварчлалын моделийг боловсруулж гаргах ажлыг хариуцуулан хийлгэх нь зүйтэй гэж үзэж байна.
	АБ-ыг бууруулах арга хэмжээний шийдвэрлэлт, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Төсөл хэрэгжих хугацаанд эх үүсвэрийн инвенторын тооцооллын дүн, тархалтын загварчлалаар хийгдэх агаар орчны үнэлгээний дүнг оруулсан жилийн ажлын тайланг 2 удаа гаргасан. Цаашид төсөл дууссаны дараа ч жилийн ажлын тайланд оруулж энэ талаар тайлагнаж байх нь зүйтэй юм. НАЧА, ЦУОШГ болон УАЧМА-нд эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлал зэргийг ашиглан агаар орчны агууламжийг урьдчилан таамагласанаар MNS-ын ялгарлын стандартыг магадлах боломжтой болох юм. Тархалтын загварчлалаар эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламжийг тодорхойлж мэдэх бөгөөд ингэснээр УБ хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг гаргаж чадах юм.
	--зэрэг	

ҮР ДҮН-2

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжлийн хүчин зүйлс)</p>	<p>Үр дүн-2 УБ хотын утааны хийн хэмжилтийг тасралтгүй тогтмол хийж байх</p> <p>Шалгуур үзүүлэлт 2.1 Төсөл хэрэгжих хугацаанд хамгийн багадаа 50 удаа утааны хийн хэмжилт хийсэн байх 2.2 Техникийн үндэслэл бүхий арга зүйн онолд тулгуурлан АБ-ын ялгарлын эх үүсвэрийн хяналт-шинжилгээг МХЕГ, УАЧМА болон НАЧА зэрэг байгууллагаар хийлгэх.</p> <p>Үйл ажиллагаа 2.1 Японд зохион байгуулагдах сургалтанд хамрагдсанаар утааны хийн хэмжилтийн онол, үндсийг сурч мэдэх. 2.2 Сорьцын цэгийг суурилуулахаар тогтон хэмжилт хийгдэх зуухыг сонгох 2.3 Стандартын хийн хэмжилтийн багаж төхөөрөмжөөр дадлага хийх 2.4 Рингельманы утааны агууламжийн хүснэгтийг ашиглах зэргээр хялбарчилсан хэмжилтийн арга болон гэрийн зууханд хэмжилт хийх аргачлалын талаар судалж үзэх. 2.5 Хамрагдах зууханд хэмжилт хийж, утааны хийн байдлыг магадлах. 2.6 Утааны хийн хэмжилттэй холбогдсон гарын авлага (сорьцын цэг, ДЦС зуух, УХЗ болон гэрийн зуухны хэмжилтүүд, хялбарчилсан хэмжилт, багаж төхөөрөмжийн ашиглалт, хяналт)-г боловсруулах 2.7 Утааны хийн хэмжилтийн талаарх гарын авлагын чанарыг сайжруулах 2.8 MNS-ын тогтоосон хэм хэмжээ, хэмжилтийн аргын зөв, зохистой эсэхийг судалж, шаардлагатай бол өөрчлөх санал гаргах 2.9 Туршилтын хяналт-шинжилгээний аргачлалыг боловсруулах 2.10 Туршилтын хяналт-шинжилгээг явуулж утааны хийн байдлыг тодорхойлж, сайжруулах шаардлага тавих</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнээр хангах</p>	<p>Гол гишүүд : ДАВААЖАРГАЛ (НАЧА), ОТГОНБАЯР (НАЧА), БАЯРМАГНАЙ (УАЧА), ЭРДЭМБИЛЭГ(ЦУОШГ), ЭНХТҮВШИН (ДЦС 2), БАТБААТАР (ДЦС 3), НУГАДАЙ (ДЦС 3), АЛТАНГЭРЭЛ (ДЦС 4), МӨНХТУЛГА (ДЦС 4) ※Японд сургалтанд явсан ДАВААДОРЖ (НАЧА), ГАНЗОРИГ (ДЦС 3) нь өөр ажилд шилжсэн тул гишүүд өөрчлөгдсөн.</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь дадлага, япон дахь сургалт)</p>	<p>【Японд дахь сургалт】 Утааны хийн хэмжилтийн сургалт (лекц + дадлага, JFE технологи судлах зэрэг, 8 дадлагажигч ×1 сар, 2010 оны 7 сар-8 сар) 【Лекц】 Утааны хийн хэмжилтийн суурь мэдлэг (8 дадлагажигч, 2010 оны 5 сар) 【Дадлага】 Утааны хийн хэмжилтийн дадлага (6 өдөр, ДЦС 4 дээр 8 дадлагажигч болон бусад хүмүүс, 2010 оны 8 сар-9 сар) Утааны хийн бодит хэмжилт 2010 он-2011 оны өвөл (21 зууханд 86 удаа, ДЦС II, болон Шдээр, УХЗ (14 газар), 2010 он 11 сар-12 сар, 2011 он 1 сар-3 сар) ※ДЦС-д хийгдсэн бодит хэмжилтэнд бүх дадлагажигч оролцсон бөгөөд УХЗ-ны бодит хэмжилтэнд хяналт-шинжилгээний талын НАЧА, УАЧМА, БОХЗТЛ-ын 4 мэргэжилтэн байсан.) Уусмалын аргаар анализ шинжилгээ хийх дадлага (4 өдөр, БОХЗТЛ дээр, 6 дадлагажигч, 2010 оны 5 сар-6 сар) Уусмалын аргаар анализ шинжилгээ хийх дадлага (3 өдөр, БОХЗТЛ дээр, 4 дадлагажигч, 2010 оны 10 сар) Утааны хийн бодит хэмжилт 2011 он-2012 оны өвөл (38 зууханд 101 удаа, ДЦС дээр (ДЦС III), УХЗ (27 газар), Гэрийн зуух, 2011 оны 11 сар-2012 оны 2 сар) Гарын авлага боловсруулах талаарх сургалт (15 өдөр, төслийн оффис дээр, 2012 оны 11 сар) Утааны хийн бодит хэмжилт 2012 он-2013 оны өвөл (хэрэгжүүлж байгаа)</p>
<p>Ур чадавхийг</p>	<p>Утааны хийн хэмжилт хийх чадвартай боловсон хүчнийг шат дараалалтайгаар бэлтгэж байгаа ба цаашид лекц сургалтыг зохион байгуулж зөв онолын мэдлэгтэй</p>

сайжруулах, ашиглах багалгаа	<p>болсноор утааны хийн хэмжилтийг тогтмол үргэлжлүүлэн мэргэжлийн төвшинд хариуцаж ажиллах чадавхитай болох юм. Мөн одоо нэвтрүүлж эхлээд байгаа зуухны бүртгэл хяналтын тогтолцооны хүрээнд цаашид үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-д утааны хийн хэмжилт хийх ажлыг үүрэг болгохоор төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр утааны хийн хэмжилт тогтмол хийгдэх явдал нь баталгаажих болно.</p> <p>2012 оны 12 сарын байдлаар НАЧА, УАЧМА болон ДЦС IV-ийн ажилтаны мэргэжлийн ур чадавхи нэлээд дээшилсэн хэдий ч одоогийн байдлаар бие даасан чадварлаг мэргэжилтэн болох арай болоогүй тул харилцан тусалж бие биеэ нөхөх хэлбэрээр баг болж ажиллах түвшинд байна. Сурч эзэмшсэн ур чадавхиа мартаггүй байхын тулд цаашид бодит хэмжилтийг идэвхтэй хийж, туршлагатай болох нь чухал юм.</p>
Тоног төхөөрөмж, байр зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт	<p>Утааны хийн хэмжилтэнд маш олон төрлийн багаж төхөөрөмж шаардлагатай болдог. Тус төслөөс 2 иж бүрдэл утааны хийн хэмжилтийн төхөөрөмжийг нийлүүлсэн бөгөөд ингэснээр УБ хотын нийт УХЗ-г утааны хийн хэмжилтэд хамруулахын тулд нэг зуухыг 3 жилд 1 удаагийн давтамжтайгаар хэмжилт хийх боломжтой болж байна. Төсөл хэрэгжих хугацаанд утааны хийн хэмжилтийн багаж төхөөрөмжийн засвар, шинэчлэлт, элэгдэл хорогдлын бараа, материал сэлбэгийг худалдан авах зэрэгт шаардагдах төсвийн төлөвлөгөөг боловсруулан төсөвт суулгах шаардлагатай байна.</p> <p>2012 оны 12 сарын байдлаар элэгдэл хорогдлын бараа, материал зэргийн жагсаалтыг боловсруулж гаргасан тул НАЧА зэрэг хариуцан ажиллах байгууллагаас төсвийн хангамжийг хийх шаардлагатай байна.</p> <p>Утааны хийн хэмжилт хийх төлбөрийн хэмжээг тогтоож, НАЧА-ны утааны хийн хэмжилтийн ажиллагааны зардлын нэг хэсэгт зарцуулах боломжийн талаар судалж үзнэ.</p>
Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	<p>Одоогийн байдлаар хэмжилтийн дүнг хүснэгтээр болон тусгай дэвтэрт тэмдэглэх байдлаар хадгалж байгаа. Цаашид одоо нэвтрүүлж эхлээд байгаа зуухны бүртгэлийн мэдээллийн санд оруулах талаар судалж ажиллах.</p>
Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн гарын авлага, стандартын үйл ажиллагааны аргачлалыг бүрдүүлэх)	<p>Утааны хийн хэмжилтийн техникийн гарын авлага боловсруулах төлөвлөгөө</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэмжилтийн ажлын горим <ol style="list-style-type: none"> 1.1 Утааны хийн хэмжилтийн гарын авлага (2011 оны 6 сар) 1.2 Утааны хийн хэмжилтийн стандарт, зааварчилгаа (2011 оны 6 сар) 1.3 Хэмжилтийн сорьцын цэг суурилуулах ажлын горим (Тодорхой бус) 1.4 ДЦС-ын утааны хий хэмжилтийн ажлын горим (Тодорхой бус) 1.5 Утааны дээж авалт, шинжилгээний ажлын горим (Тодорхой бус) 1.6 УХЗ, гэрийн зуухны утааны хийн хэмжилтийн ажлын горим (Тодорхой бус) 1.7 Багаж төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажлын горим (Тодорхой бус) 1.8 Тоос хэмжих хялбарчилсан ажиллагааны горим (Тодорхой бус) 2. Техникийн гарын авлага (Үндсэн материал) <ol style="list-style-type: none"> 2.1 Хэмжилт болон шинжилгээний ажлын урсгал (2011 оны 6 сар) 2.2 Утааны хийн хэмжилтийн фланц бэлтгэх ажил, гүйцэтгэх ажлын даалгавар-бүдүүвч зураг (2011 оны 6 сар) 2.3 Утааны хийн хэмжилтийн фланц суурилуулах ажил гүйцэтгэх ажлын даалгавар (2011 оны 6 сар) <p>1. Хэмжилтийн зааварчилгаа (Зарим хэсгийг гарын авлагад оруулсан)</p> <ol style="list-style-type: none"> 1.1 Утааны хийн хэмжилтийн стандарт, зааварчилгаа (2012 оны 12 сар, гарын авлага, протоколыг нийлүүлсэн) 1.2 Хэмжилтийн сорьцын цэг суурилуулах ажлын горим (2012 оны 12 сар) 1.3 Утааны дээж авалт, шинжилгээний ажлын горим (2012 оны 12 сар) 1.4 ДЦС-ын утааны хий хэмжилтийн ажлын горим (Тодорхой бус) 1.5 УХЗ, гэрийн зуухны утааны хийн хэмжилтийн ажлын горим (Тодорхой бус, УХЗ-ны хэсэг дууссан) <ol style="list-style-type: none"> 2. Техникийн гарын авлага <ol style="list-style-type: none"> 2.1 Хэмжилт болон шинжилгээний ажлын урсгал (2011 оны 6 сар) 2.2 Утааны хийн хэмжилтийн фланц бэлтгэх ажил, гүйцэтгэх ажлын даалгавар-бүдүүвч зураг (2011 оны 6 сар) 2.3 Утааны хийн хэмжилтийн фланц суурилуулах ажил гүйцэтгэх ажлын даалгавар

		<p>(2011 оны 6 сар)</p> <p>2.4 Хэмжилтийн техникийн гарын авлага (Утааны хийн хэмжилт : чийглэг, температур, урсгалын хурд, тоос)</p> <p>2.5 Хэмжилтийн техникийн гарын авлага Тооцооллох sheet буюу хуудсыг ашиглах арга</p> <p>2.6 Хэмжилтийн техникийн гарын авлага Автоматаар сорох төхөөрөмж</p> <p>2.7 Хэмжилтийн техникийн гарын авлага Утааны хийн дүн шинжилгээний багаж 1 (PG-250)</p> <p>2.8 Хэмжилтийн техникийн гарын авлага Утааны хийн дүн шинжилгээний багаж 2 (HT-3000)</p> <p>2.9 Техникийн үйлчилгээний гарын авлага 1 (PG-250)</p> <p>2.10 Техникийн үйлчилгээний гарын авлага 2 (насос, хошуу)</p>
Байгууллагын боловсон хүчнээр хангах (мэргэжилтэний тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх		<p>Утааны хийн хэмжилтийн мэргэжилтэнг НАЧА-ны дотороос бэлтгэх боломжтой байна. Ойрын хугацаанд боловсон хүчний дутагдлаа нөхөхийн тулд утааны хийн хэмжилтийг ДЦС-IV-д захиалж хийлгэх боломж байгааг судалж үзэх. Цаашдаа утааны хийн хэмжилтийн үйлчилгээ үзүүлдэг компани байгуулах боломжийг судалж үзэх. Технологийн үр чадавхийн асуудлаас гадна, НАЧА-нд МХЕГ-аас байцаагчийн эрх авсан хэмжилт хийх мэргэжилтэн байхгүй байгаа юм. Байцаагчийн эрхийг ахмад олон жил ажилласан хүнд өгдөг журамтай байдаг ч газар дээр ажиллаж байгаа залуу мэргэжилтэнд эрх олгох эсвэл НАЧА гэсэн байгууллагын түвшинд байцаагчийн үүргийг гүйцэтгэж хэмжилтэнд хяналт тавьдаг болгож, залуу мэргэжилтэн болон ДЦС IV-ийн мэргэжилтэн нар газар дээр ажилладаг зохион байгуулалтыг хийж чадвал боловсон хүчнийг үр дүнтэй ашиглах боломж бүрдэх юм. 2012 оны 12 сарын байдлаар НАЧА-ны хэмжилтэнд НМХГ-аас байцаагч хамтран байлцах нь илүү хэрэгжүүлэх боломжтой бодитой хувилбар гэж үзэж байна</p>
Төсөв бүрдүүлэлт		<p>Утааны хийн хэмжилт хийлгэж байгаа ААНБ-аас утааны хийн хэмжилтийн төлбөрийг авах талаар судалж үзэх ёстой. Мөн дээр дурьдсанчлан багаж төхөөрөмжийн үйлчилгээний зардал, элэгдэх материалын зардлыг багтаасан бүтэн жилийн утааны хийн хэмжилтийг явуулах төсвийг тооцож гаргах хэрэгтэй.</p>
Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох		<p>2 иж бүрдэл багаж төхөөрөмж нийлүүлсэн учраас НАЧА-д 2 хүний бүрэлдэхүүнтэй × 2 баг = 4 хүнтэй утааны хийн хэмжилтийн мэргэжилтэнтэй болох хэрэгтэй боловч захиалгаар гадны байгууллагаар хийлгэх болон бусад холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах талаар судалж үзвэл дээрх шаардлагатай болох мэргэжилтний тоог багасгаж болох юм.</p> <p><u>Ялангуяа утааны хийн хэмжилтийн хувьд хамруулах зуух ихтэй байгаа тул НАЧА-ны ажилтны ажлын ачаалал ихэсэх тул жил, сар, долоо хоног бүрийн ажил үүргийн төлөвлөгөөг боловсруулан түүний хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллах нь чухал байна. Мөн утааны хийн хэмжилтийн дүн зэрэг өгөгдлийн хяналтын тухайд ч хариуцсан ажилтан болон хяналтын горимыг тодорхой болгох шаардлагатай байна.</u></p>
Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах		<p>УАЧМА болон ЦУОШГ-д утааны хийн хэмжилтийн мэргэжилтэн байгаа бөгөөд байгууллага хооронд санамж бичиг үйлдсэнээр утааны хийн хэмжилтийн ажилд туслалцаа авах боломжтой болно гэж үзэж байна. ДЦС IV-ийн хувьд ч мөн адил хийх боломжтой боловч ТӨХК учраас бодит зардал, хүн хүчний зардал зэргийг тооцож үзсэн гэрээний загвар гаргана гэж бодож байна.</p>
АБ-ыг бууруулах арга хэмжээний шийдвэрлэлт, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох		<p>НАЧА-наас зуухны ажиллагааг журамлахад утааны хийн хэмжилтийн үр чадавхитай байх шаардлагатай бөгөөд MNS-ээр тогтоосон ялгарлын стандартаас хэтэрч байгааг ШУ-ны үндэслэлтэйгээр баталж чадсанаар зуухны үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-д зуухны ажиллагааг сайжруулах шаардлага тавих эрхтэй болох юм. Мөн утааны хийн хэмжилтийн өгөгдлийг хуримтлуулж дүн шинжилгээг хийснээр MNS-ыг илүү зохистой сайжруулан, MNS-д үндэслэсэн ялгарлын хэм хэмжээний бодитой байдлыг сайжруулж чадах юм.</p> <p>2012 оны 10 сард УХЗ-нд суурилуулсан циклоны АҮК-ийн хэмжилтийн ажил хийж, үр дүнг магадласан. Мөн гэрийн зууханд сайжруулсан түлш ашиглахын үр дүнг тодорхойлох зорилгоор утааны хийн хэмжилтийг хийсэн. НАЧА-ны ажилтан циклоны АҮК болон сайжруулсан түлшний үр дүнгийн талаар НАББҮХ-ноос зохион байгуулсан хандивлагч байгууллага болон монголын холбогдох байгууллагын уулзалт хуралдаан дээр илтгэл тавьсан.</p> <p>НАЧА-ны утааны хийн хэмжилтийн технологийг ашигласан АБ-ыг бууруулах арга</p>

ҮР ДҮН-3

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжлийн хүчин зүйлс)</p>	<p>Үр дүн-3 Холбогдох байгууллагатай хамтран НАЧА-ны ялгарлын хэм хэмжээний хяналтын чадавхийг сайжруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт 3.1 Зуухны бүртгэлийг тогтмол шинэчлэн, инвенторын өгөгдөл болон ялгарлыг багасгахтай холбогдсон үйл ажиллагаанд суурь мэдээлэл болгон ашиглах</p> <p>Үйл ажиллагаа 3.1 Өмнө хийгдсэн зуухны мэдээллийг цуглуулан цэгцэлж, японы зуухны бүртгэлийн тогтолцооноос туршлага, санаа авч монголд зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх. 3.2 Зуухны бүртгэлийн тогтолцоонд хамрагдах зуухыг сонгон тэдгээрт хийх судалгааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх 3.3 Зуухны бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэн цаашид боловсронгуй болгох 3.4 Зуух ашиглах зөвшөөрөл олгох (сайн ажиллагаатай зуухаар тодорхойлох) болзол, нөхцлийг тогтоох 3.5 Бүртгэл хяналтанд хамрагдах бүх зуухыг бүртгэн, тавьсан болзол нөхцлийг хангасан зууханд ашиглах зөвшөөрөл олгох</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнээр хангах</p>	<p>Гол гишүүд : БАТСАЙХАН (НАЧА), ГАЛЫМБЕК (НАЧА), ЦАЦРАЛ (НАЧА)</p> <p>Гишүүд : ЦОГТСАЙХАН (ХХБХ), МӨНХСАЙХАН (МХЕГ), ӨЛЗИЙЦЭЦЭГ (НМХГ), БАТБИЛЭГ (ОБХХМХ), ЭНХМАА (ЦУОШГ), ГАН-ОЧИР (ИБХ), ЗАНДАНПҮРЭВ (ХЗАЗГ) СОНИНБАЯР (ДЦС II), БОЛДСАЙХАН (ДЦС III), БУРИАД (ДЦС IV)</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь дадлага, япон дахь сургалт)</p>	<p>【Японд дахь сургалт】 Байгаль орчны хяналт, удирдлагын менежмент (лекц + дадлага, БОЯ, Токио хот, Кавасаки хот, Саппоро хот, Хитачинака ДЦС зэрэг, 5 дадлагажигч, 2 долоо хоногийн хугацаатай, 2010 оны 10 сар), Сургалтын хүрээнд тавигдах асуудал “Монголд зуухны бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардагдах зүйл”-ийг боловсруулах</p> <p>【Семинар сургалт】 Зуухны бүртгэл, хяналтын тогтолцоо (ЗБХТ), инвентор шинэчлэлийн тогтолцоог бий болгох тухай семинар (1 өдөр, Японы зуухны бүртгэлийн тогтолцооны танилцуулга (мэргэжилтэн Эбихара), Монголын зуухны тогтолцооны талаарх танилцуулга (БОАЖЯ), бусад 2010 оны 6 сар) ЗБХТ-ны семинар нь (1 өдөр, Японы агаарын бохирдлоос хамгаалах хуулийн тухай танилцуулга (мэргэжилтэн Сакурай), Агаарын тухай хуулийн шинэчилсэн агуулга, АБ-ын төлбөрийн тухай хуулийн ерөнхий агуулгын талаар (БОАЖЯ), Агаарын тухай хууль шинэчлэгдсэн агуулгын дагуу хийгдэх хяналт-шинжилгээний талаар (НМХЕГ), зуухны бүртгэлийн тогтолцооны саналын талаар (мэргэжилтэн Фукаяама), байгаль орчны хяналт удирдлагын менежментийн сургалтын агуулгыг УБ хотын удирдах дээд албан тушаалтанд сургалчлан танилцуулахын тулд зохион байгуулагдсан. Семинарын дараа орлогч дарга Ганболд болон УБ хотын Ерөнхий менежер Батад өргөн барих зөвлөмжийг боловсруулсан, 2011 оны 2 сар)</p> <p>Зуухны бүртгэлийн талаарх ажил хэргийн хуралдаан (1 өдөр, Зуухны бүртгэл хяналтын тогтолцооны тухай, бүртгэлийн маягт бөглөх зааварчилгаа (НАЧА), Зуух ашиглах зөвшөөрлийг олгох болзол нөхцөлийн талаар (Хотын Эрчим хүчний зохицуулах хороо), Зуухны галчийн сургалтын тухай (НАЧА, ЖАЙКА-ын төсөл болон ЗБХТ (Мурай мэргэжилтэн), ЗБХТ болон Агаарын тухай, Агаарын төлбөрийн тухай хуулийн холбоо (БОНХЯ), 2 үе шаттай зээлийг УХЗ-ыг шинэчлэн сайжруулахад ашиглах талаар (ЖАЙКА, ХШХЗ Монгол), ЗБХТ-г олон нийтэд танилцуулах зорилгоор зуухны үйл ажиллагаа эрхлэгч ААНБ болон</p>

		<p>хэвлэл мэдээллийн байгууллагыг оролцуулан зохион байгуулсан. 2011 оны 9 сар</p> <p>ЗБХТ-ны танилцуулга хурал (хагас өдөр ×3 удаа, ЗБХТ-ны тухай, бүртгэлийн маягт бөглөх зааварчилгаа (НАЧА), Зуухны галчийн сургалтын тухай (НАЧА), ЗБХТ-г олон нийтэд танилцуулах зорилгоор зуухны үйл ажиллагаа эрхлэгч ААНБ болон хэвлэл мэдээллийн байгууллагыг оролцуулан зохион байгуулсан. 2011 оны 9 сар</p> <p>ЗБХТ-ны танилцуулга хурал 2011 оны 9 сар-10 сар)</p> <p>2011 оны зуухны галчийн сургалт (хагас өдөр ×3 удаа, УХЗ-ны ажиллагаа, засвар үйлчилгээний талаар (НАЧА), Зуухны галчийн чадавхийг сайжруулах зорилгоор зохион байгуулсан. 2011 оны 10 сар)</p> <p>2012 оны зуухны галчийн сургалт (хагас өдөр× 3 удаа, Зуухны ажиллагааны үлгэр жишээ байдал, болон муу ажиллагааны жишээ (видео хичээл) (НАЧА), Зуухны галчийн ур чадавхийг сайжруулах зорилгоор зохион байгуулсан. 2012 оны 11 сар)</p> <p>Системийн бүрдүүлэлт болон мэдээллийн сангийн систем үүсгэх захиалгын ажлын хяналт (хагас өдөр, Мурай мэргэжилтэн)</p> <p>Үр дүн -3-ийг хариуцсан ажилтанд мэдээллийн сангийн системийг үүсгэн бүрдүүлэхэд захиалагч талын зүгээс системийн бүрдүүлэлтийн процесс, ажлын захиалагч тал болон гүйцэтгэгч талуудыг ажлын хувиарлалт, үүсгэх системийн талаар нэгдсэн ойлголттой болгоход чиглэсэн хэрэгслүүр зэргийн талаар тайлбарласан. (2012 оны 11 сар)</p>
	Ур чадавхийг сайжруулах, ашиглах баталгаа	<p>Зуухны бүртгэлийн маягыг тараах болон цуглуулах ажлын тухайд, албан ёсоор Үндэсний Статистикийн Хорооны зөвшөөрлийг авсан тул тус бүртгэлийн мэдээллийн дүн, нэгтгэлийг тайлагнаж байх үүрэгтэй болсон. Мөн зуухны бүртгэлийн мэдээллийн сан нь инвентор, тархалтын загварчлалын системд оруулах өгөгдөл болох тул жил бүр бүртгэлийг явуулсанаар мэдээллийн сантай ажиллах, ашиглах ур чадавхи сайжрах юм.</p> <p>НМХЕГ болон НАЧА хамтран хэрэгжүүлэх хяналт-шинжилгээний нэг хэсэг болох утааны хийн хэмжилтийн өгөгдөл нь зуухны бүртгэлийн мэдээллийн санд хадгалагдах болно.</p> <p>Мэдээллийн сангийн мэдээллийг НАЧА нь зуухны үйл ажиллагааг хянаж журамлахдаа үндэслэл болгохоос гадна ЦУОШГ-ын боловсруулж гаргах инвентор, тархалтын загварчлалын шинэчлэл, БОНХЯ-ны “Агаарын төлбөрийн тухай” хуулийн төлбөрийн хэмжээг тогтооход ашиглах зэргээр байгаль орчны хяналт, удирдлагын менежментэд хэрэг болох хэрэгцээтэй өгөгдөл болох юм. Тиймээс байгаль орчны хяналт, удирдлагын менежменттэй холбоотой төрийн албаны байгууллагуудыг өгөгдлөөр хангаж чадахуйц болох юм.</p>
	Тоног төхөөрөмж, байр зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт	Төслийн хүрээнд ЗБХТ-нд зориулсан 1 компьютер болон системийн программ (Visual studio)-аар хангана.
	Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	<p>Зуухны байгууламжаар биечлэн явж хийсэн судалгааны дүн (зуухны болон яндангийн мэдээлэл)-г WORD болон EXCEL хэлбэрээр өгөгдлийн файл үүсгэх.</p> <p>ЗБХТ-ны дүнд зуухны бүртгэлийн мэдээллийн санг бий болгож, хамааралт мэдээллийн сангаар нэгдсэн хяналт тавих.</p>
	Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн гарын авлага, стандартын үйл ажиллагааны	<p>Мэдээллийн сангийн хүснэгтийн тодорхойлолт</p> <p>Е-R зураг (Entity Relationship Diagram)</p> <p>Ажлын дараалал, урсгалын схем</p> <p>Зуухны бүртгэлийн системтэй ажиллах зааварчилгаа</p> <p>Зуухны бүртгэлийн системийн гарын авлага</p>

	аргачлалыг бүрдүүлэх)	
	Байгууллагыг боловсон хүчнээр хангах (мэргэжилтэний тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	ЗБХТ-ны мэдээллийн сангийн системийг цаашид сайжруулан засварлах шаардлагатай болох тул энэ ажлыг аутсорсинг буюу гадны байгууллагаар хийлгэхдээ НАЧА нь захиалагч тал болж өөрчилж шинэчлэх шаардлагатай зүйлийг зөв тодорхойлон гаргаж чаддаг болох нь чухал бөгөөд бүртгэлийн тогтолцооны бэлтгэл ажлыг хийснээр тус тогтолцооны талаарх ойлголтыг гүнзгийрүүлэн, бүртгэлийн өгөгдлийг боловсруулсанаар хийгдэх ажлыг ойлгож мэдэх юм. Мөн аутсорсинг хийхийн тулд мэдээллийн сан болон бүртгэлийн маягтыг оруулах, гаргах системтэй ажиллах зааварчилгааг сайжруулах.
	Төсөв бүрдүүлэлт	<u>Зуухны галчийн сургалтанд хамрагдаж авсан батламж нь 3 жилийн хүчинтэй бөгөөд сургалтыг жил бүр зохион байгуулна. Бүртгэлийн маягтыг боловсруулах, зуух ашиглах зөвшөөрлийн бичиг, зуухны галч, механикчын сургалтанд хамрагдсан батламж, сургалтын материал сэдвийг боловсруулах болон сургалтыг явуулах газрыг түрээслэх зардлыг жил болгон төсөвт суулгаж байх шаардлагатай</u>
	Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	Зуухны бүртгэлийн мэдээллийн сан ашиглалтыг хариуцан ажиллах 2 ажилтантай болох нь зүйтэй гэж үзэж байна.
	Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах	НАЧА нь УАЧА, БОХЗТЛ-ийн хийж байгаа утааны хийн хэмжилтийн дүн, Эрчим хүчний зохицуулах хорооноос олгодог тусгай зөвшөөрөл (1500 кВт-аас дээших хүчин чадал бүхий зуух ажиллуулах зөвшөөрөл)-ийг олгож буй байдал, агуулгын талаар тодорхой мэдээлэлтэй байх талаар санамж бичиг солилцох. Мөн зуухны бүртгэлийн мэдээллийн санд байгаа өгөгдөл, мэдээллийг НМХГ, БОАЖЯ гэсэн байгууллагууд ч ашиглаж болохуйц болгон, бүртгэлийн агуулга, мэдээллийг мэдүүлэн танилцуулах
	АБ-ыг бууруулах арга хэмжээний шийдвэрлэлт, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Зуухны бүртгэлийн мэдээлэл нь НАЧА-наас цаашид зууханд хяналт тавьж, журамлах ажлын гол суурь мэдээлэл нь болохоос гадна утааны хийн хэмжилтийн дүн, зуухыг сайжруулсан байдлын тэмдэглэл зэрэг нь тухайн зуухыг ашиглалтаас гарсаны дараа ч хадгалагдан үлдэх боломжтой болсоноор янз бүрийн харьцуулалт, судалгааг хийхэд үндсэн мэдээлэлтэй болж байгаа юм. Мөн зуухны бүртгэлийн мэдээлэл нь агаар бохирдуулах эх үүсвэрийн инвенторыг боловсруулахад ашиглагдах бөгөөд тухайн мэдээлэлд тулгуурлан нэмэлт хийгдэх судалгааг төлөвлөх боломжтой болох юм.
	--зэрэг	

ҮР ДҮН-4

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжлийн хүчин зүйлс)</p>	<p>Үр дүн-4 НАЧА-аас агаарыг бохирдуулах бодисын эх үүсвэрт авах арга хэмжээг санаачлан гаргах</p> <p>Шалгуур үзүүлэлт 4.1 20-оос доошгүй агаар бохирдуулах бодисын гол эх үүсвэрт (суурин эх үүсвэр) үзлэг оношлогоог хийж, түүнд авах арга хэмжээний саналыг боловсруулж гаргах 4.2 Зуухны хэмжилтийн амсарын цэгийг гарган, шаталтыг нэмэгдүүлэх зэрэг ажиллагааг сайжруулах бодлогын талаар зуухны үйл ажиллагаа эрхлэгч байгууллага, эзэмшигч нартай хэлэлцэн зөвшилдөж, хэлэлцүүлгийн товч тэмдэглэлийн эмхтгэлтэй болох.</p> <p>Үйл ажиллагаа 4.1 MNS болон зуухны бүртгэлийн тогтолцооны талаар семинар хийх 4.2 Шаталтын хяналт болон агаарын бохирдлоос хамгаалах арга хэмжээний ерөнхий онолын талаар лекц явуулах. 4.3 Агаар бохирдуулагч гол эх үүсвэрт үзлэг оношлогоо хийж, тоног төхөөрөмж болон хяналтын тал дээр авах арга хэмжээний санал гаргах. 4.4 Агаар бохирдуулагч гол эх үүсвэрт авах арга хэмжээний саналыг семинараар танилцуулах. 4.5 Муу болон сайн ажиллагааг нягталж үзэх. 4.6 Нийт хамруулах зуух нь ялгарлын стандарт хангах зэрэг хууль эрх зүйн үүргээ биелүүлэхэд чиглэсэн зохион байгуулалт, тогтолцооны санал гаргах.</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнээр хангах</p>	<p>Гол гишүүд : СЭДЭД (НАЧА), ЦОЛМОН (НАЧА), док. ЦЭЕН-ОЙДОВ (ШУТИС), Гишүүд : СОНИНБАЯР (ДЦС II), БОЛДСАЙХАН (ДЦС III), БУРИАД (ДЦС IV), ГАН-ОЧИР (ИБХ), ЗАНДАНПҮРЭВ (ХЗАЗГ), БАТТӨР (ШУТИС), ОТГОН (БҮҮНА), БИЛГҮҮН (БЭХХТ)</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь дадлага, япон дахь сургалт)</p>	<p>【Лекц】 Агаарын бохирдол (АБ)-ын эсрэг авах арга хэмжээ-Эрчим хүч дулаан хэмнэлт (ЭХДХ)-ийн талаарх семинар (4 өдөр, “Холбогдох агуулгыг “ажлын гүйцэтгэл/чанарын хяналт” хэсгээс харах, 2010 оны 10 сар) АБ-ын эсрэг авах арга хэмжээнд зуухны хүчин чадал ашиглалтын хяналтын сургалт (НАЧА, ДЦС, Их сургуулийн холбогдох хүмүүс 1 өдөр, НАЧА, УХЗ-ны холбоотой хүмүүс 1 өдөр, 2011 оны 2,3 сар) УХЗ-ны галчийн сургалт (2012 оны 4 сар, 2012 оны 10 сар)</p> <p>【Сургалтын материал, сэдэв боловсруулалт】 Зуухны галчийн сургалтын материал боловсруулах (1) УХЗ ажиллуулах үндсэн зарчим, 2) Дулаан дамжуулалтын онол, 3) Шаталтын онол, 2011 оны 6-9 сар) 【Видео хичээл бэлтгэх】 УХЗ-ны ажиллагаа, шаталтыг хянах талаарх видео хичээл (2012 оны 10 сар)</p> <p>【Дадлага】 АБ-ын эсрэг авах арга хэмжээтэй холбогдуулсан зуухны дулаан хяналтын дадлага (ДЦС-3 дээр 1-өдөр, УБТЗ-ын Засварын төв дээр 2 өдөр, 2010 оны 12 сар, УХЗ-дээр 1 өдөр, 2011 оны 2 сар) 【Ажлын байран дахь сургалт】 АБ-ын эсрэг авах арга хэмжээг судалж үзэх (ДЦС (Ялангуяа ДЦС-3-н зуухны тухайд буцламтгай үет шаталтад системтэй болгон сайжруулах хүсэлтийн саналыг боловсруулах), Үйлдвэр-1, УХЗ-2 2010 оны 6 сар) АБ-ын эсрэг авах арга хэмжээний хүрээнд ЭХДХ-ийн потенциал нөөцийг оношлох (ДЦС-Үйлдвэр зэрэгт, 2010 оны 6 сар) АБ-ын эсрэг авах арга хэмжээний хүрээнд ЭХДХ-ийн хялбарчилсан оношлогоо (ДЦС(3), Үйлдвэр (8), оффис (1), УХЗ (3) 2010 оны 10 сар) АБ-ын эсрэг авах арга хэмжээний хүрээнд ЭХДХ-ийн дэлгэрэнгүй оношлогооны хэрэгжүүлэлт, тайлбар (Үйлдвэр (2), 2011 он 1,3 сар, оношлогоо (нэмж 2 үйлдвэр) (6 сар)) Циклоны АҮК-ийг тодорхойлох хэмжилт (2012 оны 10 сар) АБ-ыг бууруулах арга хэмжээний саналтай холбогдуулсан ЭХДХ-ийн</p>

		нарийвчилсан оношлогоог хэрэгжүүлэх (Үйлдвэр (2), 2012 оны 10 сар)
Ур чадавхийг сайжруулах, ашиглах баталгаа		Одоогийн НАЧА-ны бүтэц, зохион байгуулалтын хувьд техникийн ур чадавхи суралцах болон түүнийг цаашид сайжруулан авч явахад дутагдалтай хүндрэлтэй зүйлүүд байгаа. Иймд тус төслийг дууссанаас хойших байдлыг бодож үзвэл Их сургууль зэрэг албан ёсны гадны байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй юм.
Тоног төхөөрөмж, байр зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт		Хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардалгатай оношлогооны зориулалттай багаж төхөөрөмжтэй болох шаардлагатай. (даралт-температурын мэдрэгч болон дата цуглуулагч, хэт авианы зарцуулалт хэмжигч, термографикийн камер, хэт авиагаар хий алдалт хайгч зэрэг)
Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт		Зуухны хүчин чадал, үзүүлэлтийн үнэлгээний дүнг хүснэгтэн тооцооллын хэлбэрээр, ЭХДХ-ийн нарийвчилсан оношлогооны дүнг тайлангийн хэлбэрээр бэлтгэж зуухны үзүүлэлтийн үнэлгээний дүнг 16, ЭХДХ-ийн оношлогооны тайлан 7-г тус тус боловсруулсан гаргасан. ЭХДХ-ийн нарийвчилсан оношлогооны тайлан, 1) ЭХХ-ийн оношлогооны дүнгийн товч агуулга, 2) Үйлдвэрийн танилцуулга, 3) ЭХХ-ийн оношлогооны агуулга, 4) Монгол талаас оролцогч мэргэжилтэнд оношлогоо болон оношлогооны багаж хэрэгсэлтэй ажиллах техникийн ур чадавхийг зааж сургах.
Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн гарын авлага, стандартын үйл ажиллагааны аргачлалыг бүрдүүлэх)		АБ-ыг бууруулах арга хэмжээ, ЭХДХ-ийн талаарх сургалтын материалыг цаашид ашиглах боломжтой. АБ-ыг бууруулах арга хэмжээний талаарх сургалтын материал 1) Нүүрсний тухай ерөнхий мэдлэг, 2) Зуухны АҮК-ын ерөнхий агуулга, 3) Зуухны АҮК-ийн анализ шинжилгээний үндсэн ойлголт, мэдлэг, 4) Зуухны АҮК-ийн хичээл, 5) Зуухны АҮК-ийн байнгын хяналт, 6) Зуухны АҮК-ийг сайжруулах, 7) Японы цэвэр нүүрсний технологи, 8) Зуухны гэмтэл, засварын жишээ болон авах арга хэмжээ, 9) УХЗ-ны тухай ЭХДХ-ийн техникийн оношлогооны талаарх сургалтын материал Японы ЭХДХ-ийн байдал (ЭХДХ-ийн хэрэгцээ шаардлага, японы ЭХДХ, түүний хяналтын тогтолцоо, авах арга хэмжээний хэрэгжилтийн явц), 2) ЭХДХ-ийн технологи (Зуух, хийн компрессор, сэнс салхилуур, гэрэлтүүлгийн ЭХДХ), 3) Японд ЭХДХ-ийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
Байгууллагыг боловсон хүчнээр хангах (мэргэжилтэний тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх		<u>АБ-ын эсрэг авах арга хэмжээний хувьд НАЧА-нд зуухны ажиллагааг хариуцсан 1 мэргэжилтэн байдаг бөгөөд цаашид мэргэжлийн мэдлэг бүхий боловсон хүчнийг сайжруулах шаардлагатай байгаа. 2011 оны зух зуухны үйл ажиллагаа эрхэлдэг компанид ажиллаж байсан туршлагатай шинэ ажилтанг авсан хэдий ч хариуцсан ажлын ачаалал ихтэйн улмаас тус мэргэжилтэнг үйл ажиллагаанд оролцуулж ажиллуулах боломж хязгаарлагдмал байдаг.</u> <u>ЭХДХ-ийн хувьд НАЧА-ны хамтрагч ажилтан нь туйлын идэвхтэй ажилладаг боловч техникийн талын суурь мэдлэг дутагдаж байдаг тул НАЧА дангаараа ЭХХ-ийн оношлогоог хийхэд бэрхшээлтэй юм.</u>
Төсөв бүрдүүлэлт		Төслийн хугацаанд хэрэгцээтэй багаж төхөөрөмж болон элэгдэлт барааны хангамжийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай.
Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох		НАЧА-ын хувьд цаашид боловсон хүчнээ сайжруулан нэмэгдүүлж өөрсдийн хүчээр хийх боломжтой хэдий ч бэлтгэл оношлогоог хийж, оношлогоонд хамрагдах байгууламжийг сонгон тогтоож, бодит нарийвчилсан оношлогоог холбогдох байгууллагад даалган хийлгэх нь зүйтэй болов уу гэж мэргэжилтний баг үзэж байна. Үүнд шаардагдах оношлогооны зардлыг тухайн ажил гүйцэтгэгч байгууллага нь хариуцах ёстой юм.
Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах		Мэргэжилтний баг нь АБ-ын эсрэг авах арга хэмжээний хувьд ШУТИС-ын харьяа Эрчим хүчний инженерийн сургуульд, ЭХДХ-ийн хувьд ШУТИС-ийн харьяа Барилгын эрчим хүч хэмнэлт (БЭХХ)-ийн төвд тус тус технологийн ур чадавхийг эзэмшүүлэн, холбогдох оношлогоог хариуцуулан хийлгэх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн НАЧА нь ШУТИС-тай АБ-ыг бууруулах арга хэмжээнд шаардлагатай багаж

		төхөөрөмж болон ЭХДХ-ийн хэмжилтийн багаж төхөөрөмжийн ашиглалтын талаар хэлэлцээр байгуулсан. ШУТИС-тай хамтран ажилласнаар оношлогоог идэвхийлэн сайтар хийх шаардлагатай болж байна.
	АБ-ыг бууруулах арга хэмжээний шийдвэрлэлт, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Энэ салбар нь ялгарлын стандартын хэм хэмжээг хэтрүүлсэн байгууламжид ажиллагаагаа сайжруулах талаар зөвлөгөө өгч, удирдаж ажиллахад чиглэх бөгөөд ялангуяа НАЧА нь техникийн тал дээр голлон ажиллаж зуухны ажиллагааг сайжруулахаар ажиллах үүргийг гүйцэтгэх болно. Хөрөнгө санхүүжилтын тал дээр ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж байгаа 2 үе шаттай хөнгөлөлттэй зээл (ХШХЗ)-ийг ашиглах нь зохимжтой гэж үзэж байна. Гэвч ХШХЗ-д жижиг дунд үйлдвэрүүд хамрагдах тул улсын байгууллагын хувьд тусд нь хөрөнгө санхүүжилтыг судлах шаардлагатай юм
	--зэрэг	

ҮР ДҮН-5

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжлийн хүчин зүйлс)</p>	<p>Үр дүн-5 НАЧА болон холбогдох байгууллага нь төслийн хүрэх үр дүн 1-4 ийг нэгтгэн, АБ-ын хяналтын менежментэд тусган, мэдээллийг нийтэд тараан дэлгэрүүлэх боломжтой болох.</p> <p>Шалгуур үзүүлэлт 5.1 Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүд нь М/М зэрэг илтгэл мэдээллийг ашиглан, НАББҮХ болон нийслэлийн иргэдтэй төслийн үр дүнгийн мэдээллийг хуваалцах</p> <p>Үйл ажиллагаа 5.1 АБ-ын эсрэг авах арга хэмжээтэй холбоотой японы мэдлэг, туршлагыг сургалт, семинараар танилцуулах 5.2 Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүдийг Японд сургалтанд хамруулсанаар японы байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн талаар сурч мэдэх 5.3 Мэргэжилтний баг нь тогтмол Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүдтэй зөвлөгөөн, хэлэлцүүлэг явуулж, агаар орчныг хамгаалах хяналт, удирдлагын менежментийн зохистой саналыг боловсруулан гаргаж, М/М зэрэг тайлан болгож гаргах 5.4 Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүд нь хандивлагч байгууллагатай тогтоосон харилцаа, дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй нийслэлийн хэмжээний агаарын орчны хяналтын хөтөлбөрт хувь нэмрээ оруулах. 5.5 Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүдтэй хамтран 2-оос доошгүй удаа агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг сурталчлан таниулах зорилго бүхий сургалт, семинарыг зохион байгуулах.</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнээр хангах</p>	<p>Гол гишүүд : БАТСАЙХАН (НАЧА), ЦОЛМОН (НАЧА) Гишүүд : ЦЭЭПИЛ (БОНХЯ), ӨЛЗИЙЦЭЦЭГ (НМХЕГ), ЭНХМЭЭ (ЦУОШГ), ЦОГТСАЙХАН (ХХБХ), БАТБИЛЭГ (ОБХХМХ), САРАН (БОНХЯ), НЯМДОРЖ (НМХГ), ДАВААСҮРЭН (ЭХЯ), БОЛОРМАА (ЗТБХБЯ), НЯМДАВАА (УАЧМА), АЛТАНГЭРЭЛ (ИБХ), ГАН-ОЧИР (ИБХ), БОЛДХҮҮ (ЭХЯ), ЗАНДАНПҮРЭВ (ХЗАЗГ)</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь дадлага, япон дахь сургалт)</p>	<p>【Япон дахь сургалт】 Байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалт (эхний жилийн) (лекц + үйл ажиллагаатай танилцах, БОЯ, Токио хот, Кавасаки хот, Саппоро хот, Хитачинака ДЦС зэрэг, 5 дадлагажигч 2 долоо хоногийн хугацаатай, 2010 оны 10 сар) сургалтын агуулга нь “монголд зуухны бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай зүйлс” саналыг боловсруулах Байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалт (2 дах жилийн) (лекц + үйл ажиллагаатай танилцах, БОЯ, Токио хот, Кавасаки хот, Осака хот, Исого Цахилгаан станц зэрэг, 6 дадлагажигч 2 долоо хоногийн хугацаатай, 2011 оны 10 сар), инвентор, тархалтын загварчлалыг АБ-ыг бууруулах арга хэмжээнд ашиглах талаар ойлголтыг гүнзгийрүүлэх, сургалтын даалгавар “АБ-ыг бууруулах төлөвлөгөө болон АБ-оос хамгаалах хэлэлцээрийг байгуулахад чиглэсэн холбогдох байгууллагын ажлын уялдаа холбооны талаарх зөвлөмж”-ийг боловсруулах. Байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалт (3 дах жилийн) (лекц + үйл ажиллагаатай танилцах, БОЯ, Токио хот, Саппоро хот, JFE төмөрлөгийн компани зэрэг, 6 дадлагажигч 2 долоо хоногийн хугацаатай, 2012 оны 12 сар), сургалтын даалгавар “АБ-ыг бууруулах арга хэмжээний саналыг боловсруулах зааварчилгаа болон хариуцан ажиллах байгууллагын талаарх санал” боловсруулах. 【Семинар, ажил хэргийн хуралдаан, уулзалт хуралдаан】 Судалгааны тайлангийн ажил хэргийн хуралдаан (1 өдөр, төслийн агуулгыг танилцуулах, 2010 оны 4 сар) ХЗХ-ны анхдугаар хуралдаан (1 өдөр, судалгааны тайлангийн хэлэлцүүлэг зэрэг, 2010 оны 4 сар) Зуухны бүртгэлийн тогтолцоо, инвенторыг шинэчлэх тогтолцоог бүрдүүлэх тухай семинар (1 өдөр, Япон монгол дахь зуухны бүртгэлийн нарийвчлалын талаар, 2010 оны 6 сар)</p>

		<p>ХЗХ-ны 2-р хуралдаан (1 өдөр, явцын тайлан-1 баталгаажуулалт зэрэг, 2011 оны 1 сар)</p> <p>Зуухны бүртгэлийн тогтолцооны талаар семинар (1 өдөр, Японы зуухны бүртгэлийн тогтолцооны тухай, Агаарын тухай хуулийг шинэчлэх, АБ-ын төлбөрийн тухай хуулийн товч агуулгын талаар, зуухны бүртгэлийн тогтолцооны саналын танилцуулга, хэлэлцүүлэг 2011 оны 2 сар)</p> <p>Зуухны бүртгэлийн тухай ажил хэргийн хуралдаан болон Зуухны бүртгэл хяналтын тогтолцооны танилцуулга хурал (1 өдөр, Зуухны бүртгэл хяналтын тогтолцооны танилцуулга, тайлбар зэрэг, 2011 оны 9 сар)</p> <p>ХЗХ-ны 3-р хуралдаан (1 өдөр, Явцын тайлан-2 зөвшөөрөл, тогтвортой хөгжлийг хангах матриц (Ver1)-ын танилцуулга, хэлэлцүүлэг, 2011 оны 9 сар)</p> <p>ХЗХ-ны 4-р хуралдаан (1 өдөр, Явцын үнэлгээний дүнгийн тайлан, 2011 оны 12 сар)</p> <p>Төслийн үйл ажиллагааг танилцуулах семинар (анхны) (1 өдөр, 2012 оны 6 сар)</p> <p>Төслийн үйл ажиллагааг танилцуулах семинар (2-р дугаар) (1 өдөр, 2012 оны 9 сар)</p> <p>ХЗХ-ны 5-р хуралдаан (1 өдөр, Явцын тайлан-3 зөвшөөрөл, 2012 оны 10 сар)</p> <p>ХЗХ-ны 6-р хуралдаан (1 өдөр, Эцсийн шатны үнэлгээний дүнгийн тайлан, 2012 оны 12 сар)</p> <p>【Бусад】</p> <p>Зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулсан хотын Захирагчийн захирамж (2011 оны 8 сар)</p> <p>Зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулсан Үндэсний Статистикийн Хорооны зөвшөөрөл (2011 оны 9 сар)</p> <p>Өнөөг хүртэл НАЧА нь цаашид бохирдуулах эх үүсвэрийг хянаж журамлахад нэмэр болох тус бүртгэл хяналтын тогтолцоог бий болгох талаар голлон ажиллаж ирсэн бөгөөд цаашид инвентор, тархалтын загварчлалыг ашигласан агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зөвлөмж, MNS –ыг шинэчлэх зэрэг асуудалд анхаарах ажиллах төлөвлөгөөтэй байна.</p> <p>2012 оны 12 сард НАЧА болон ШУТИС-ын хооронд АБ-ыг бууруулах арга хэмжээ болон ЭХДХ-ийн оношлогоо, хэмжилтийн багаж төхөөрөмжийн ашиглалтын талаар санамж бичиг байгуулсан бөгөөд ШУТИС-тай уялдаа холбоотой ажилласанаар оношлогооны ажлыг сайжруулах юм.</p>
	Ур чадавхийг сайжруулах, ашиглах баталгаа	НАЧА-наас хэрэгжүүлэх АБ-ын хяналт, удирдлагын менежментийн үйл ажиллагааг аль болох хууль тогтоомж, захирамж гаргуулах хэлбэрээр агуулгыг тодотгон, баталгаажуулж авах нь чухал юм. Ингэснээр төсөв, боловсон хүчнийг бүрдүүлэх боломжтой болох ба хяналт удирдлагын чадавхи, аргачлалыг ашиглах боломж ч нэмэгдэх болно
	Тоног төхөөрөмж, байр зэрэг ажиллах орчинг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт	Энэ салбарын хувьд чухал шаардлагатай багаж төхөөрөмж байхгүй.
	Мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглалтын хяналт	Тогтолцоог бүрдүүлэх явцад холбогдох байгууллагад харилцсан баримт бичгийг цэгцлэн, архивлан хадгалах нь зүйтэй юм.
	Ажлын гүйцэтгэл, чанарын хяналт (Техникийн гарын авлага, стандартын үйл ажиллагааны аргачлалыг бүрдүүлэх)	Тогтолцоог бүрдүүлэх явцад үйлдсэн холбогдох баримт бичиг зэргийг тэмдэглэж бүртгэсэн бүртгэлийн бичиг байвал цэгцлэн, архивлаж хадгалах.
	Байгууллагыг боловсон хүчнээр хангах	Албаны дарга, дэд даргын хувьд холбогдох байгууллагатай хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулан гүнзгийрүүлж, боловсон хүчний ажлын эрх үүрэг, хариуцлагын хүрээг өргөжүүлэх талаар чармайн ажиллах нь чухал байна.

	(мэргэжилтэний тоог нэмэгдүүлэх), мөн аутсорсинг хийх	
	Төсөв бүрдүүлэлт	Зуухны бүртгэл хяналтын тогтолцоо шиг тусгай тогтолцоо, журмыг бий болгосноор энэ нь жил бүр хэрэгжүүлэх шаардлагатай ажлын нэг болох тул үүнд зарцуулагдах ажиллах хүчний болон шаардагдах материалын зардлыг төсөвт суулгадаг болох нь НАЧА-ны гүйцэтгэх ажил үүргийг улам тодотгон өгч, төсөв болон боловсон хүчнээ нэмэгдүүлж сайжруулах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.
	Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг бий болгох	<u>Албаны дарга болон дэд даргаас гадна дараахи албан тушаалтныг бэлтгэн янз бүрийн хяналт, удирдлагын шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх. Мөн гүйцэтгэх ажил болон хариуцах ажилтанг тогтоон томилож, ажлын бүтээмжийг сайжруулахын зэрэгцээ хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж баталгаажуулах</u>
	Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах	<u>Техникийн болон бодлогын тал дээр одоогийн НАЧА болон холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байгаа</u> тул БОНХЯ, ЭХЯ, ЦУОШГ, УАЧМА, БОХЗТЛ, ЗАА-ны ИБХ, НМХГ, ШУТИС зэрэг байгууллагуудтай санамж бичиг солилцох зэргээр харилцаа холбоогоо бэхжүүлэн ажиллах. 2012 оны 12 сард НАЧА болон ШУТИС-ын хооронд АБ-ыг бууруулах арга хэмжээ болон ЭХДХ-ийн оношлогоо, хэмжилтийн багаж төхөөрөмжийн ашиглалтын талаар санамж бичиг байгуулсан. 2012 оны 12 сарын Байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтын хүрээнд АБ-ыг бууруулах арга хэмжээний саналыг боловсруулах зааварчилгаа болон хариуцан ажиллах байгууллагын талаарх саналыг боловсруулсанаар цаашид энэ асуудал дээр илүү тодорхой ажиллах боломжтой болно.
	АБ-ыг бууруулах арга хэмжээний шийдвэрлэлт, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох	Агаарын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд заагдсан АБ-ын хяналт, удирдлага болон холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа холбооны бүтэц зохион байгуулалтын агуулгаас НАЧА-ны хувьд шамдан ажиллах боломжтой удирдлага менежментийн асуудлыг хайж олох, мөн шийдвэрлэх шаардлагатай шинэ асуудлыг хотын захирагчийн түвшинд санал болгон тавих, зөвлөмж гаргах зэргээр өөрсдийн хариуцан гүйцэтгэх ажлыг бий болгосноор НАЧА-ны хариуцлага, ажлын эрх үүрэг асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. 2012 оны 12 сарын байдлаар төслийн мэргэжилтэн, НАЧА, ИБХ зэрэг байгууллагууд хэлэлцсэн АБ-ыг бууруулах арга хэмжээний саналаас 3 саналыг НИТХ-д танилцуулж батлуулан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан. Цаашид бусад арга хэмжээний саналын талаар хэлэлцүүлэг явуулж, хотын орлогч даргад танилцуулахаар төлөвлөж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

<p>Чадавхийн хөгжил (ЧХ)-ийн үе шат (тогтвортой хөгжлийн хүчин зүйлс)</p>	<p>Төслийн зорилго Нийслэлийн болон бусад холбогдох байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх, ур чадавхийг сайжруулахад голлон анхаарч, УБ хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, хяналтын чадавхийг сайжруулан бэхжүүлэх</p> <p>Шалгуур үзүүлэлт</p> <ol style="list-style-type: none"> 1. НАЧА нь бусад холбогдох байгууллагатай хамтран төсөл хэрэгжилтийн хугацаанд 2 удаа эх үүсвэрийн хог хаягдлын ялгарлын инвенторын нэгдсэн дүн, агаар орчны үнэлгээний дүн болон ялгарлын хэмжилтийн дүнг оруулсан жилийн тайлан гаргах 2. НАЧА нь бусад холбогдох байгууллагатай хамтран УБ хотын Ерөнхий менежер бөгөөд ЗАА-ны даргад хандан жилийн тайландаа үндэслэн төслийн хугацаанд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаар 5 саналыг боловсруулан, өргөн барьж зөвлөмж болгох 3. НАЧА нь бусад холбогдох байгууллагатай хамтран, төслийн хугацаанд хийгдэх дугуй ширээний ярилцлага болон бусад уулзалт ярилцлаганд оролцож төсөл хэрэгжилтийн явцын дүнг тайлагнан танилцуулах. 4. Хотын Захирагчийн захирамж гаргуулах зэргээр албан ёсоор төрийн бодлого болон зохион байгуулалтын хүрээнд баталгаажуулах эсвэл НАЧА-тай улсын болон нийслэлийн хэмжээний холбогдох байгууллага хоорондын түвшинд хэлэлцээрийн бичиг байгуулах зэргээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн төрийн бодлогын болон хууль эрх зүйн , бүтэц зохион байгуулалтын хүрээг бүрдүүлэх.
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэх боловсон хүчнээр хангах</p>	<p>Үр дүн-1 ДАВААЖАРГАЛ (НАЧА), АЛТАНГЭРЭЛ (НАЧА), САНЧИРБАЯР (НАЧА), ЭНХМАА (ЦУОШГ), ӨНӨРБАТ (УАЧМА)</p> <p>Үр дүн-2 Гол гишүүд : ДАВААЖАРГАЛ (НАЧА), ОТГОНБАЯР (НАЧА), БАЯРМАГНАЙ (УАЧМА), ЭРДЭМБИЛЭГ (БОХЗТЛ), ЭНХТҮВШИН (ДЦС II), БАТБААТАР (ДЦС III), НУГАДАЙ (ДЦС III), АЛТАНГЭРЭЛ (ДЦС IV), МӨНХТУЛГА (ДЦС IV)</p> <p>Үр дүн-3 БАТСАЙХАН(НАЧА), ГАЛЫМБЕК (НАЧА), ЦАЦРАЛ (НАЧА)</p> <p>Үр дүн-4 СЭДЭД(НАЧА), ЦОЛМОН (НАЧА), док. ЦЭЕН-ОЙДОВ (ШУТИС)</p> <p>Үр дүн-5 БАТСАЙХАН (НАЧА), ЦОЛМОН (НАЧА)</p>
<p>Техникийн ур чадавхи эзэмшүүлэлт (сургалт семинар, ажлын байран дахь дадлага, япон дахь сургалт)</p>	<p>Үр дүн-1 【Семинар】 Зуухны бүртгэл, хяналтын тогтолцоо (ЗБХТ), эх үүсвэрийн инвентор (1 өдөр, 2010 оны 6 сар) Эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлал (1 өдөр, 2011 оны 3 сар) Суурь оны инвентор, тархалтын загварчлал (1 өдөр, 2011 оны 6 сар) 【Сургалт】 Инвентор, тархалтын загварчлал (4 өдөр, 2011 оны 6 сар) Инвентор, тархалтын загварчлал (нийт 4 өдөр, 2012 оны 9 сар, 11 сар) Хөдөлгөөнт болон бусад эх үүсвэрийн инвенторын сургалт (нийт 4 өдөр, 2011 оны 6 сар, 2012 оны 11 сар) 【Ажлын байран дахь сургалт】 Хөдөлгөөний эрчмийн судалгаа (2010 оны 9 , 11 сар, 2011 оны 9 сар, 2012 оны 11 сар) Зуухны байгууламжаар биечлэн явж хийсэн судалгаа (2010 он 11 сар-2011 он 2 сар) Автомашин ялгарлын коэффициентийг тооцооллоход шаардлагатай мэдээллийг цуглуулах (2011 оны 8 сар-2012 оны 3сар, 2012 оны 8 сар-2012 оны 11 сар) ДЦС-ын үнсэн сангаас хийсэх үнсний хэмжилт зэрэг үйл ажиллагаа (2010 оны 12 сар, 2011 оны 3 сар, 5-6 сар, 2011 оны 9 сар, 2011 оны 11 сар-2012 оны 7 сар) 【Япон дахь сургалт】 Инвентор, тархалтын загварчлалыг АБ-ын хяналт, удирдлагын менежментэд</p>

		<p>ашиглах (2011 оны 10 сарын 16-29 өдөр) АБ-ыг бууруулах арга хэмжээний саналтай холбогдуулсан АБ-ын хяналт, удирдлагын менежмент (2012 оны 12 сарын 9-22 өдөр) Үр дүн-2 【Япон дахь сургалт】 Утааны хийн хэмжилтийн сургалт (лекц + дадлага, 8 хүн×1 сар, 2010 оны 7-8 сар) 【Лекц】 Утааны хийн хэмжилтийн суурь мэдлэгийн сургалт (8 хүн, 2010 он 5 сар) 【Дадлага】 Утааны хийн хэмжилтийн дадлаг (6 өдөр, 8 хүн ба бусад, 2010 оны 8-9 сар) Утааны хийн бодит хэмжилт 2010 он-2011 оны өвөл (21 зууханд 86 удаа, ДЦС дээр (ДЦС II, III), УХЗ (14 газар), 2010 он 11-12 сар, 2011 он 1-3 сар) Уусмалын аргаар анализ шинжилгээ хийх дадлага (4 өдөр, БОХЗТЛ дээр, 6 дадлагажигч, 2010 он 5-6 сар) Уусмалын аргаар анализ шинжилгээ хийх дадлага (нийт 3 өдөр, БОХЗТЛ дээр 4 дадлагажигч, 2010 оны 10 сар) Утааны хийн бодит хэмжилт 2011он-2012 оны өвөл (38 зууханд 101 удаа, ДЦС дээр (ДЦС III), УХЗ (27 газар), гэрийн зуух, 2011 оны 11 сар-2012 оны 2 сар) Гарын авлага боловсруулах талаарх сургалт (15 өдөр, төслийн ажлын өрөө, 2012 оны 11 сар) Утааны хийн бодит хэмжилт 2012 он-2013 оны өвөл (хийж байгаа) Үр дүн-3 【Япон дахь сургалт】 Байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалт (лекц + дадлага, 5 дадлагажигч ×2 долоо хоногийн хугацаатай, 2010 оны 10 сар) 【Семинар】 ЗБХТ, эх үүсвэрийн инвентор (1 өдөр, 2010 оны 6 сар) ЗБХТ-ны талаархи семинар (1 өдөр, 2011 оны 2 сар) ※Семинарын дараа хотын орлогч дарга Ганболд болон Ерөнхий менежер Бат нарт зөвлөмжийг өргөн барьсан. ЗБХТ-г нэвтрүүлэх талаар ажил хэргийн хуралдаан (1 өдөр, 2011 оны 9 сар) ЗБХТ-ны танилцуулга хурал (хагас өдөр× 3 удаа, 2011 оны 10 сар) 2011 оны зуухны галчийн сургалт (хагас өдөр × 3 удаа, 2011 оны 10 сар) 2012 оны зуухны галчийн сургалт (хагас өдөр × 3 удаа, 2012 оны 11 сар) Системийг нэвтрүүлэх ажлын дараалал болон захиалгын хяналт (хагас өдөр, 2012 оны 11 сар) Үр дүн-4 【Лекц】 АБ-ын эсрэг авах арга хэмжээ, ЭХДХ (4 өдөр, 2010 оны 10 сар) АБ-ын эсрэг авах арга хэмжээнд зуухны чанарын хяналт (2 өдөр, 2011 оны 2 сар, 3 сар) УХЗ-ын галчийн сургалт (2012 оны 4 сар, 2012 оны 10 сар) 【Сургалтын материал боловсруулах】 Зуухны галчид зориулсан сургалтын материал боловсруулах (2011 оны 6-9 сар) 【Видео хичээл бэлтгэх】 УХЗ-ны ажиллагааг, шаталтыг хянах талаарх видео хичээл (2012 оны 10 сар) 【Дадлага】 АБ-ыг бууруулах арга хэмжээний хүрээнд зуухны дулаан алдагдлыг хянах (4 өдөр, 2010 оны 12 сар, 2011 оны 2 сар) 【Ажлын байран дахь сургалт】 АБ-ыг бууруулах арга хэмжээг судлах (ДЦС, Үйлдвэр, УХЗ, 2010 оны 6сар) ЭХДХ-ийн боломжит нөөцийн оношлогоо (ДЦС, Үйлдвэр зэрэг, 2010 оны 6 сар) ЭХДХ-ийн хялбарчилсан оношлогоо (ДЦС, Үйлдвэр, оффис, УХЗ, 2010 оны 10сар) ЭХДХ-ийн нарийвчилсан оношлогооны хэрэгжилт, танилцуулга (Үйлдвэр, 2011 оны 1 сар, 3 сар) Циклоны АУК-ийн хэмжилт (2012 оны 10 сар)</p>
--	--	--

АБ-ыг бууруулах арга хэмжээтэй холбогдуулан ЭХДХ-ийн оношлогоог хэрэгжүүлэх (Үйлдвэр (2), 2012 оны 10 сар)

Үр дүн-5

【Япон дахь сургалт】

Байгаль орчны хяналт, удирдлагын менежмент (лекц+дадлага, 5 дадлагажигч ×2 долоо хоногийн хугацаатай, 2010 оны 10 сар)

Байгаль орчны хяналт, удирдлагын менежмент (Төслийн 2 дах жил) (лекц+дадлага, 6 дадлагажигч × 2 долоо хоногийн хугацаатай, 2010 оны 10 сар)

Байгаль орчны хяналт, удирдлагын менежмент (Төслийн 3 дах жил) (лекц+дадлага, 6 дадлагажигч × 2 долоо хоногийн хугацаатай, 2012 оны 12 сар)

【Семинар, ажил хэргийн хуралдаан, уулзалт хуралдаан】

Судалгааны тайлангийн хуралдаан (1 өдөр, 2010 оны 4 сар)

ХЗХ-ны анхдугаар хуралдаан (1 өдөр, судалгааны тайлангийн хэлэлцүүлэг зэрэг, 2010 оны 4 сар)

ЗБХТ, эх үүсвэрийн инвентор (1 өдөр, 2010 оны 6 сар)

ЗБХТ-ны талаарх семинар (1 өдөр, 2011 оны 2 сар)

ХЗХ-ны 2-р хуралдаан (1 өдөр, 2011 оны 1 сар)

ЖСеминарын дараа хотын орлогч дарга Ганболд болон хотын Ерөнхий менежер Бат нарт зөвлөмжийг өргөн барьсан.

Зуухны бүртгэлийн талаарх ажил хэргийн хуралдаан, мөн ЗБХТ-г нэвтрүүлэх талаар танилцуулга хурал (1 өдөр, 2011 оны 9 сар)

ХЗХ-ны 3-р хуралдаан (1 өдөр, 2011 оны 9 сар)

ХЗХ-ны 4-р хуралдаан(1 өдөр, 2011 оны 12 сар)

Төслийн үйл ажиллагааг танилцуулах семинар (анхны) (1 өдөр, 2012 оны 6 сар)

Төслийн үйл ажиллагааг танилцуулах семинар (2-р дугаар) (1 өдөр,2012 оны 9 сар)

